Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2012. 05 сар. №008 (018) www.mongolianeconomy.mn

Бодлогын хүү Засгийн бодлогыг бут ниргэсэн үү

Давхар татварын гэрээнд “но” их

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МӨН ЧАНАР ЮУ ВЭ



Шог зургийг А.Амарсайхан

OMEGA

HOUR VISION. THEIR VISION.





OMEGA | ORBIS

Swiss Watch Shop

Наран Пойнт, Хувьсгалчдын гудамж-9
Утас: 326435
www.sws.mn

Rio Tinto

Rio Tinto

Монголын Үндэсний
Олимпийн хороо
АЛТАН ТҮНШ



Оюу Толгой төсөл,
Олимпийн багийн амжилт
Рио Тинтогийн бахархал

www.riotinto.com/london2012
www.ot.mn

уурхайн гүнээс
аваргын энгэрт



Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:
Д.Бэхбаяр
9999 4248

Үүсгэн байгуулагч, Орлогч Эрхлэгч:
И.Отгонжаргал
8800 6228

Англи хэлний редактор: Террэнс Эдвардс
Орчуулагч: Б.Үүрийнтуяа
Сэтгүүлчид: Х.Хулан
Э.Зоригт
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Б.Уганбаяр
Б.Энхмарт
Дизайнер, Вэб мастер: Ш.Оюундарь

Маркетингийн менежер: Д.Барианжав 88800825
Б.Энхцэцэг 99015476
Борлуулалтын менежер: С.Цэнд-Аюуш

"Economy" ТВ студи
Дэд захирал: Ц.Буянбат 88112885
Зураглаач: Ц.Бат-Отгон
График дизайн Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

Утас/Факс: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

Борлуулах цэгүүд:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mal"

MONGOLIAN ECONOMY

14 хоног тутамд танд хүрнэ

ЗАХИАЛГЫГ:

"Монгол шуудан"
"Түгээмэл шуудан"
"Sky" шуудан
"UB Post" шуудангийн салбарууд болон сэтгүүлийн редакцид авч байна.


Утас: 7011-5476
8880-0825

Мөнгөний бодлогын мөн чанар юу вэ




Инфляци үүсэж байгаа шалтгааныг нь маш сайн бодож үзэх ёстой. Эдийн засгийн онолоороо хоёр талтай...8

Давхар татварын гэрээнд “но” их



Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо. ..16

Лизинг эдийн засгийг доош чангааж, үндэсний үйлдвэрлэлд саад болж байна



Зээлийн багцад хэрэглээний зээлийн эзлэх хувийн жин бага биш байгаа нь сайн үзүүлэлт биш гэж бодож байна...19

“Mongolian noble Fibre” брэндийг дэлхийн зах зээлд удахгүй гаргана



Чанартай түүхий эдээр, олон улсын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнийг өндөр үнээр худалдаж, Монголын брэндийг дэлхийн зах зээлд гаргах зорилготой...40

ЭДИЙН ЗАСАГ

8 Мөнгөний бодлогын мөн чанар юу вэ

12 “Төв”-гүй Төвбанк

13 Бодлогын хүү Засгийн бодлогыг бут ниргэсэн үү

15 Давхар татварын гэрээнд “но” их

19 Лизинг эдийн засгийг доош чангааж, үндэсний үйлдвэрлэлд саад болж байна

21 Хөгжлийн бэрхшээлтэй иргэн “үйлдвэрлэгч” Монгол

24 Эдийн засгийн өсөлт нь хөрөнгө оруулалт, тогтвортой байдлыг шаардаж байна

26 Цэлийтэл нээгдсэн цонхыг зөв ашиглаж чадах болов уу

28 Очир эрдэнийн хот

31 Хувираа гадагшаа сургууль хөөцөлдөх нь цаг, мөнгө дэмий үрдэг

УУЛУУРХАЙ

32 “Хүннү коал” ба монгол менежмент

36 2013

БИЗНЕС

38 Ноолуурын үнэ газарджээ

40 “Mongolian noble Fibre” брэндийг дэлхийн зах зээлд удахгүй гаргана

САНХҮҮ

Монголын хөрөнгийн бирж өнгөрсөн сарын 30-наас эхлэн Т+3 буюу харилцагч үнэт цаас худалдаж авсан өдрөөс хойш ажлын гурав хоногийн дотор төлбөрөө хийж гүйцэтгэдэг механизм руу шилжлээ. Тус системд шилжсэнээр үнэт цаасны хөрвөх чадвар, арилжааны үнийн дүн, зах зээлийн эргэлтийг сайжруулахад чухал ач холбогдолтой гэж хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүд онцолж байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцож, хөрөнгө оруулалт хийхэд таатай орчин бүрдсэн аж. Үүнтэй холбоотойгоор банкуудтай төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаасны төлбөр тооцооны төвөөс эхэлсэн байна.



“Э-транс ложистикс” компани Монголын хөрөнгийн зах зээл дээр өнгөрсөн сарын 24-нд IPO хийсэн. Тус компани нь 7.7 сая ширхэг хувьцааг хөрөнгө оруулагчдад санал болгосон байна. Харин 13.19 сая ширхэг хувьцааг худалдаж авах захиалга ирсэн аж. “Э-транс ложистикс” компани 924 сая төгрөгийг дотоодын зах зээлээс амжилттай босгож чадсан нь энэ оны анхны IPO болсон юм. Тус компани нь Замын -Үүдэд бараа бүтээгдэхүүн дамжуулан ачих үйл ажиллагаа явуулдаг байна.

Лондоны металлын биржэд долоон ам.долларааар худалдаалагдаж байсан зэсийн үнэ нэг тонн нь 8407 ам.доллар болж өсчээ. Өнгөрсөн даваа гарагт/дөрөвдүгээр сарын 30/ Хятад улсын эрэлтээс үүдэн нэг тонн зэсийг 8496.75 ам.доллараар худалдаасан нь сүүлийн сар орчмын хугацаан дахь хамгийн өндөр ханш юм. Хятадын томоохон зэс үйлдвэрлэгч компаниуд зэсийн хомсдол болон дээрх үнийн хэт өсөлтийг бууруулах зорилгоор Лондоны металлын биржэд зэсийн катод нийлүүлэхээр болжээ. Энэ жил дэлхийн зэсийн хэрэглээ 240 мянган тонноор нэмэгдэх тооцоо гарсан боловч ирэх жил гэхэд зэсийн үйлдвэрлэл нэмэгдэх тул хомсдолд орохгүй хэмээн Олон улсын зэс судлах байгууллагаас (ICSG) мэдэгдсэн юм.

ЭДИЙН ЗАСАГ

Монголын үндэсний статистикийн газар, Дэлхийн банкнаас Монгол Улсын ядуурлын түвшин 2011 онд 29.8 хувь болж буурсан тухай мэдээллийг өнгөрсөн сарын эхээр мэдээлсэн. Албаны хүмүүс ийм мэдээлэл өгч байгаа ч иргэд итгэж ядан сууна. Үнэмшихээс аргагүй нэг шалтгаан нь Дэлхийн банктай хамтарсан гэдэгт байгаа юм. Иргэд яагаад итгэхгүй байна вэ? Тэд “Хүний хөгжил сан”-гаас олгож буй 21 мянган төгрөгөө авахаар урт дараалалд зогсож, махны үнэд дарлуулсаар байгаа учраас тэр. Мөн нийт 713 мянган өрхийн 36 хувь нь нэн ядуу, гурван монгол хүн тутмын нэг нь ядуу гэсэн бүртгэл байдаг гэсэн Үндэсний статистикийн хорооны мэдээлэл бий. Сүүлийн арван жилд Монголын ядуурал хэрхэн буурсныг графикаас харъя. /2007 онд ядуурлын түвшин 27 хувьд хүрсэн нь шинэ төрсөн хүүхэд болон сар, улирал тутамд хүүхдэд мөнгө олгож эхэлсэнтэй холбоотой аж/


ДААТГАЛ

Даатгалын зуучлагч компаниуд өнгөрөгч гуравдугаар сарын байдлаар 28.2 сая



төгрөгийн зуучлалын орлого олсон байна. Мөн даатгалын хохирол үнэлэгч компаниуд 49.1 сая төгрөгийн тохиолдлын хохирлыг үнэлж 6.9 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Дээрх хугацаанд компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 5506.0 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 284.0 сая төгрөгөөр, давхар даатгалд

UBIBOR хүү



UBIBOR хүүгийн хамгийн оргил үе нь хямралын дараах буюу 2009 оны 1-р улиралд тохиож байсныг та графикаас харж болно. Харин энэ оны зарим үзүүлэлт хямралын үеийнхтэй ойролцоо байгаа нь одоогийн UBIBOR хүү оргил үеийн тэр түвшинд хүрч болзошгүй

Эх сурвалж. Purplebook.mn

Олон улсын зах зээл дээр хөрөнгө босгож (IPO) байгаа компаниудын салбарын бүтэц

96.60%	Уул уурхайн бүтээгдэхүүний салбар
0.20%	Нэхмэлийн үйлдвэрийн бүтээгдэхүүний салбар
0.40%	Цахилгаан шуудан цахим хэрэгслийн салбар
0.50%	Хүнсний бүтээгдэхүүний салбар
1.40%	Газрын тос, хийн бүтээгдэхүүн

Эх сурвалж. Bloomberg, euroasia capital.com

Ядуурлын түвшин сүүлийн арван жилд /хувиар/



Эх сурвалж. MYCX

төлсөн хураамж 4431.2 сая төгрөгөөр тус тус өсчээ.

ХЯТАД

Урд хөршийн үйлдвэрлэлийн индекс өнгөрсөн гуравдугаар сард 53.1 хувийн үзүүлэлттэй



байсан бол дөрөвдүгээр сард 53.6 хувь болон өссөн тухай Reuters агентлагийн шинжээчид мэдээллээ. Мөн тус улсын эдийн засгийн өсөлт гадаад, дотоодын эрэлт буурсан, мөнгөний хатуу бодлогын улмаас өнгөрсөн нэгдүгээр сараас 8.1 хувь болон буурсан байна. Энэ нь сүүлийн гурван жилд байгаагүй муу үзүүлэлт хэмээн албаныхан мэдээлж байгаа ч өнгөрсөн сард тодорхой хэмжээний ахиц гарсан тухай мөн Reuters агентлаг онцолжээ.

“Хятад Монголын хөрөнгө оруулагчдын чуулган 2012”-ыг Хятадын LONGAN хууль зүйн фирм, VOLVO барилгын тоног төхөөрөмжийн групп хамтран ирэх сарын 18-нд Бээжин хотноо зохион байгуулахаар болжээ. Чуулганаар Монголын уул уурхай, барилгын салбарт хөрөнгө оруулах боломж, хууль эрх зүйн орчны талаар голчлон хэлэлцэх юм байна. Түүнчлэн хоёр улсын бизнесийн байгууллагууд хамтран ажиллах төслөө ч танилцуулах аж. Чуулганд Хятадаас “Шиньхуа групп”, “China Gold Group”, “Хятадын Үндэсний Хөгжлийн банк” зэрэг 50 гаруй, Монголоос 40 орчим компани урьдчилсан байдлаар оролцохоор болжээ. Түүнчлэн чуулганыг Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монголын үндэсний уул уурхайн асоциаци, Хятадын Уул уурхайн холбоо дэмжин оролцох юм байна.

ЯПОН

Байгалийн гамшгийн улмаас өнгөрсөн онд уналтад орсон Япон улсын хөрөнгийн зах зээл эргэн сэргэж буйг Bloomberg-ийн цахим хуудсанд мэдээлжээ. Биржийн мэдээлснээр өнгөрсөн онд 31 хувиар буурсан Nikkei 225 хувьцаа дунджаар 69 хувиар өсөх урьдчилсан таамгийг Bloomberg агентлагийн 2600 гаруй шинжээчийн гаргасан судалгаа илтгэж буй аж. “Япон орлогын хувьд айдгаа ардаа хийсэн” хэмээн тус улсын ING Mutual Funds Management байгууллагын хөрөнгө оруулалтын менежер Масафуми Ошидэн хэлжээ.
Хөрөнгө оруулагчид Bloomberg агентлагийн гаргасан таамагтай санал нэг байгаа аж. Учир нь, сүүлийн үеийн мэдээллээр урьдчилсан таамгаас даруй 24.5 хувиар илүү ашигтай худалдаа хийсэн нь тус улсад харъяалагдаж буй бондуудыг дэлхийн 60 том зах зээл дэх хамгийн үнэтэй үнэт цаас болгожээ.

ОРОС

Оросын газрын тосны томоохон компани “Роснефть”-ийн ТУЗ-өөс хувьцаа эзэмшигчиддээ өнгөрсөн оны жишгээр нэг хувьцаанд 3,45 рубль төлөхийг санал болгож байна. Компанийн хэвлэлийн мэдээллээр, энэ нь 2010 оны хэмжээнээс 25 хувиар илүү байгаа аж. “Роснефть”-ийн хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн саналыг хүлээж авах тохиолдолд нийт 36,6 тэрбум рублийн ногдол ашиг хуваарилагдана. Оросын газрын тосны хамгийн том хувийн компани “Лукойл” ногдол ашгаа 27,1 хувь буюу нэг хувьцааг 75 рубль хүртэлх дүнгээр нэмэгдүүлэх тухай мэдээлсэн билээ. Мөн “Лукойл”-оос ногдол ашгийг жилд бусад нефтийн концернуудын адил нэг бус, харин хоёр удаа олгох боломжийг судалж байгаа гэж мэдэгдсэн байна.

“Газпром” компани ч мөн адил 2011 оны ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх төлөвтэй аж. Дөрөвдүгээр сарын эхний байдлаар хувьцаа эзэмшигчдэд нэг хувьцаанд 8,97 рубль олгохыг компанийн удирдлагаас санал болгов. Энэхүү шийдвэрийг баталсан тохиолдолд “Газпром” ногдол ашигтаа 199 тэрбум рубль буюу 2010 оноос 2,3 дахин их ногдол ашиг өгөх аж.



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТ

МӨНГӨНИЙ БОДЛОГО

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МӨН ЧАНАР ЮУ ВЭ



Шог зургийг А.Амарсайхан

Амьтан хүний аазгай хөдөлгөсөн айсуй сонгуулийн зэрэгцээ нийгмийн харшлыг хөдөлгөж байгаа нэгэн зүйл бол мөнгөний бодлого юм. Уг нь бол сонгууль мөнгөний бодлого хоёр зэрэгцэн оршиж асуудал үүсгэж, ард түмнийг бухимдуулах учиргүй. Гэтэл манайд улстөрчдийн бүтэлгүй амлалт, бэлэн мөнгөний тараалт, төсвийн хэт тэлэлтээс болж инфляцийн ногт тайларсан. Нэгэнт хазаар, ноггүй сул давхих болсон инфляци өсөлт гэдгийг харин ч нэг үзүүлж өгч байна.

Эдийн засгийг боомилох аюултай инфляцийг хяналтаасаа алдчихгүйн тулд Монголбанк мөнгөний хатуу бодлого явуулж хамаг байдгаараа хичээж буй. Нөгөө талд бодлогын хүүг өсгөх тусам зээл үнэтэй болж, энэ нь эргээд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд халгаатай нь тодорхой харагдах аж.

Үнийн өсөлтөд дарамтлуулж, зээлийн эрэлд мордсон иргэдийн зүгээс Монголбанкинд бодлогын хүү өсгөж, хувийн хэвшлийг боомилохоос өөр зохицуулалт байхгүй гэж үү. Махны үнийг хэн бууруулах ёстой вэ гэсэн ширүүхэн асуултуудыг Төвбанкны өндөр саарал байшингийн зүг нисгэнэ. Харин Монголбанкныхан ямар ч байсан одоогийн нөхцөлд буруу зүйл хийгээгүй гэдэгтэй итгэлтэй байгаа нь илт.

Мөнгөний бодлогын талаар үнэн зөв, улс төрөөс ангид хариултыг хаанаас олох вэ. Энэхүү ээдрээтэй асуудлын чиг шугам, чиглэх луужинг эдийн засагчид тодорхой хэлэх нь мэдээж. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл энэ дугаартаа мөнгөний бодлогыг онцолж байна. Зөв, буруу нь хаанаа байгаа нь үл мэдэгдэх мөнгөний бодлогын толгой эргүүлсэн түмэн асуудлын талаар эдийн засагчдын юу гэхийг анхааралтай уншаарай.

Мөн манайх мөнгөний бодлоготой холбоотой нарийн ширийн асуудлуудын учир начрыг тунгаах гэж оролдохын сацуу иргэдийн худалдан авах чадвар сул, мөнгө улам бүр үнэтэй болж байгаа энэ үед олон нийтэд шалих шалихгүй зээл тавьж, өрөнд орохоос зайлсхийж, аль болох хадгаламжтай монгол болохын төлөө хичээн ажиллахыг уриалж байна.

"MONGOLIAN ECONOMY" СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

1. -Төвбанк бодлогын хүүгээ хамгийн сүүлд 0,5 нэгжээр нэмлээ. Мөн арилжааны банкны заавал байлгах нөөцийн хэмжээг ч нэмэгдүүлэхээр боллоо. Тус арга хэмжээг өнөөдрийн нөхцөл байдалд Монголбанк хангалттай гэж үзсэн бололтой. Инфляци өсөхгүй гэсэн баталгаа байна уу. Та энэ талаар юу хэлэх вэ?

2. -Манай эдийн засаг эрчимтэй тэлж байна. Ийм үед инфляцийг бодлогын хүүгээр намнадаг цаг өнгөрсөн. Тиймээс Монголбанкны мөнгөний бодлогын арга хэрэгсэл өөр байх ёстой гэж тайлбарлах хүмүүс байна. Үнэхээр бодлогын хүү ирээдүйтэй арга мөн үү?

3. -Монголбанк Засгийн газарт Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөгийн санхүүжилтийг олголоо. Энэ нь хууль зөрчсөн үйлдэл биш үү. Төвбанкны хараат бус байдлыг хэрхэн хангах ёстой вэ?

4. -Ирэх сонгууль инфляцийн түвшинд нөлөөлөх болов уу?



Ц.БАТСҮХ
/СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхмийн эрхлэгч/

Нэг нь тараадаг, нөгөө нь хумьдаг бодлого явуулаад ямар ч үр дүнд хүрэхгүй

1. Монголбанкны хувьд инфляцийг хазааарлаж барих арга хэрэгсэл нь ганцхан бодлогын хүү болчихлоо. Үүнээс өөр сонголт одоогоор Төвбанкинд алга. Бодлогын дүнд инфляцийг тодорхой хэмжээнд барина. Гэхдээ сөрөг тал нь илүү давамгай болчихож магадгүй. Учир нь, бодлогын хүүг нэмэхээр зээлийн хүү өснө. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын эх үүсвэр илүү үнэтэй болж эхэлнэ. Энэ нь эргээд бизнес эрхлэгчид болон зээлээр тэжээгдэж буй зах зээлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах сул талтай. Зах зээлдээ ч дарамттай.

Инфляци үүсэж байгаа шалтгааныг нь маш сайн бодож үзэх ёстой. Эдийн засгийн онолоороо хоёр талтай. Нэг нь эрэлт, нөгөө нь нийлүүлэлт. Нийлүүлэлтийн бодит шокуудаас үүдэлтэй инфляци бий болж байна. Одоогийн мөнгөний бодлогын хэрэгсэл бол эрэлтийг хааж байгаа юм. Энэ нь зах зээлд нийлүүлэгдэж буй мөнгөний амны уутыг боож байна гэсэн үг. Бодлогын хүүгээр мөнгөний хэмжээг багасаж, инфляцийг барина гэж үзэж болох юм. Гэхдээ эрэлтээс үүдэлтэй инфляцийг бол мөнгөний бодлогоор барьж чадахгүй.

2. Цалингийн нэмэгдэл, бэлэн мөнгөний амлалт эргээд эрэлтийн инфляцийг өдөөж байна. Мөн зах зээлийн эмзэг байдлыг зарим хүмүүс ашиглаад хувийн тоглолт хийгээд байгаа нь инфляци өсөх нэг үндэслэл. Тухайлбал, махны асуудал байна. Цэвэр нийлүүлэлтээс хамаарсан учраас жил бүрийн хавар махны үнэ өсөж, инфляцийг хөөрөгддөг. Эдийн засагт бодитой үүсэж буй эрэлт бол махны хомсдол, шатахууны үнийн өндөр өсөлт. Тэгэхээр эдийн засагт бодитой шалтгаанаар бий болж байгаа инфляци дээр мөнгөний бодлого явуулаад үр ашиггүй. Нөлөөлөхгүй. Тиймээс инфляцийн шалтгааныг эрэлт, нийлүүлэлтийн талдаа хэдэн хувьтай байгааг ялгаж салгах хэрэгтэй.

Нийлүүлэлтийн бодит шалтгааныг арилгах нь Төвбанкны үүрэг бус. Харин Засгийн газрын шийдэх асуудал. Мөнгөний бодлогоос үл хамаарсан зах зээлийн гажуудал байна. Үүнийг л Засгийн газар зохицуулах ёстой. Хавар махны хомсдолгүй байх үүргийг Засгийн газар хариуцах ёстой. Засгийн газар, Төвбанк хоорондоо тохиролцох ёстой. Нэгдсэн зөвшилцөлд хүрэх хэрэгтэй. Засгийн газар бэлэн мөнгө тарааж байгаагийн цаана нь үйлдвэрлэл хөгжихгүй, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадахгүй байна. Барааны нийлүүлэлтийг ихэсгэх хангалтынхаа бодлогыг төрөөс тайлбарлахгүй байгаа нь өөрөө эрсдэл юм. Тиймээс Төвбанк барааны хомсдолтой эдийн засагт мөнгө нийлүүлж, улам бүр хомсдол үүсгэж, инфляцийг хөөрөгдөхөөс сэрэмжлээд эрэлтийн талыг хаасан шийдвэр гаргасан. Эцсийн »

дүндээ хоорондоо бодлогын чиг зорилгоо нэгтгэж, зөвшилцөх л ёстой. Түүнээс нэг нь тараадаг, нөгөө нь хумьдаг бодлого явуулаад ямар ч үр дүнд хүрэхгүй. Үүнийг ойрын дөрвөн жилийн үйл явдал тод харууллаа шүү дээ.

3. Сонгуульд ялсан нам нь Засгийн газрыг бүрдүүлж, өөрийнхөө бодлогыг хэрэгжүүлж байна. Манайх шиг төр нь амлалтаа биелүүлэхийн төлөө явдаг оронд мөнгө шаардлагатай. Үүнийг хангахын тулд бэлэн мөнгө хэвлээд зах зээлийн эрэлтийг хангачихаж болно. Ийм хэмжээний мөнгө зах зээлд ороод ирэхэд эсрэг талд нь бодит үйлдвэрлэл өсөөгүй учраас шууд үнийн хөөрөгдөл бий болдог. Тиймээс Засгийн газрыг ийм дураараа үйлдэл хийлгэхгүйн тулд л Төвбанк мөнгийг нь базаад сууж байдаг юм.

Төвбанкны тухай хуульд Засгийн газарт зээл өгч болно гэсэн заалт хүртэл байдаг. Улс дотроо Засгийн газрын эцсийн зээлдэгч бол Төвбанк байж болно. Харин Засгийн газар энэ зээлээ гурван сарын дотор буцааж төлөх үүрэгтэй. Одоогийн авсан зээлээ гурван сарын хугацаанд Засгийн газар төлнө гэдэг эргэлзээтэй. Дараагийн шинэ Засгийн газрын нүүрийг үзэж мэднэ. Ерөнхий сайд, Төвбанкны ерөнхийлөгч бол эрхийн хувьд тэгш. Ерөнхий сайд хэзээ ч Төвбанкны ерөнхийлөгчийг дуудаад үүрэг өгч болохгүй шүү дээ, хуулиараа хориотой.

Монголбанкны бие даасан байдлын тухайд ерөнхийлөгчийг нь УИХ-аас томилдоггүй, өөр хуулиар зохицуулагдсан байвал илүү хараат бус болно.

4. Сонгуулийн дараа инфляци одоогийн түвшингээ хандгална. Харин есдүгээр сараас инфляци нэмэгдэж магадгүй. Өмнөх 2008 оны сонгуулийн дараа долоо, наймдугаар сард инфляци тогтвортой байсан. Ер нь сонгуулийн өмнө Засгийн газар бүхий л үнийг нь барьж болох бараа бүтээгдэхүүнийг өсөлтийг торгоож тогтоосон байдаг шүү дээ. Сонгуулийн дараа Засгийн газар ямар бодлого хэрэгжүүлэхээс инфляцийн дүр зураг тодорхой болно.



О.ЧУЛУУНБАТ
/УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга/

Сонгуулийн дараа арай ухамсартай төрийн бодлого явуулах байх

1. Мөнгөний бодлогын хүүгээр инфляцид нөлөөлнө гэсэн ойлголтоос би нэлээд өөр бодолтой явдаг. Би ч өөрөө Монголбанкинд бодлого тодорхойлж явсан болохоор анхандаа ийм бодолтой байсан. Бодлогын хүүг нэмэгдүүлэхээр зах дээр байгаа мөнгөний хэмжээ багасна. Энэ нь инфляцийг бууруулахад нөлөөлнө гэсэн номлол нь том зах зээл, том том санхүүгийн зах зээлд биелэлээ олдог юм байна. АНУ, Япон, Хятадад ийм бодлого нөлөөлж байна. Монголын хувьд ийм замаар явж үзсэн. Манайд таарахгүй юм билээ. Номлол нь Монголд ажиллахгүй байсан.

2. Манайд бодлогын хүүгээс илүү ханшаа тогтвортой барих ёстой. Бидний өдөр тутмын идэж ууж байгаа өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний 70-80 хувийг гадаад зах зээлээс авч байгаа болохоор инфляцид нөлөөлж байна. Инфляци бол ганцхан мөнгөнөөс шалтгаалдаг гэж хүмүүс ойлгоод байна шүү дээ. Мөнгө их байвал инфляци өсдөг.

Мөнгийг нь багасгахаар инфляци буурчихдаг гэсэн ойлголт хоёр талтай. Манайх шиг жижигхэн зах зээлтэй, өөрсдөө юу ч үйлдвэрлэхгүй улсад бараа бүтээгдэхүүний хангамжаас хамааралтай олон асуудал бий. Мөнгийг нь яаж ч багасгасан барааг нь оруулахгүй бол тэр барааны үнэ өсөж л таарна. Барааны хомсдолыг санаатай, санамсаргүй байдлаар дээшлүүлсэн тохиолдолд эрэлт үүснэ. Тиймээс зах зээлийн барааны хангамжид анхаарах ёстой. Энэ бол Засгийн үүрэг. Ялангуяа, Хятадаас оруулж ирж байгаа бараа бүтээгдэхүүн зах зээлд маш хурдан нийлүүлэгдэж байх хэрэгтэй. Олон шат дамжлагагүйгээр хэрэглэгчиддээ шууд хүрдэг баймаар байна. Төрийн шалгалт, татвараар дамжихгүй байх тусмаа л зах дээр аль болох бодит үнээрээ хүрнэ. Энэ асуудалд дутагдалтай ажиллаж байгаа учраас инфляцийн гол түгжээ болоод байна.

3. Хуулийнхаа дагуу олгосон. 21 мянган төгрөгийг хамтарсан Засгийн газраас гаргаж хөтөлбөр, төлөвлөгөө, аргачлалаа УИХ-аар батлуулсан. Хүний хөгжил сангийн 21 мянган төгрөг зургадугаар сараар эцэслэгдэнэ. Ер нь 21 мянган төгрөгийг зүгээр тараах нь буруу. Төрөөс халамжлах хэрэгтэй хүмүүсээ л харж хандах хэрэгтэй байсан. Зорилготой, зөв оносон халамж байх нь чухал. Түүнээс та бид хоёрыг халамжлаад хэрэггүй биз дээ.

- Ажиллах, хөдөлмөр эрхлэх чадвартай, боломжтой. Тиймээс хөгшчүүл болоод хүүхдүүдээ шууд болон шууд бусаар халамжлах шаардлагатай. Хүүхдүүдийг хүн болгох дэд бүтцээ Монгол Улс байгуулж чадаагүй шүү дээ. Төрөх эмнэлэг гэхэд л өнөөдөр баригдаж байна.

4. Сонгуулийн дараа улс төржилтөөсөө салах байх. Төсвийн алдагдлыг гурван хувьд байхаар баталсан. Энэ хэмжээндээ байвал инфляцид шууд нөлөөлөхгүй. Арилжааны банкуудын чанаргүй зээлийн хэмжээ ч хэвийн дүнтэй байна. Нэгдүгээрт, инфляци богино хугацаанд огцом харайгаад явчихгүй байх. Хоёрдугаарт, сонгуулийн дараа төрийн бодлого арай ухамсартай явуулах болов уу. Төрийн хариуцлагатай засаг бүрдэнэ байх.



Б.ТӨВШИНТӨГС
/Эдийн засаг, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, эдийн засагч/

Засгийн газар Монголбанкны хараат бус байдалд шууд халдсан. Энэ бол ухралт

1. Засгийн газрын зардал өмнөх жилийнхээсээ 35 орчим хувиар өсөхөөр төлөвлөгдсөн, мөн бэлэн мөнгө тарааж байгаагийн нөхцөлд үнийн дарамт цаашид хадгалагдана. Мөнгөний бодлогынх нь зүгээс аваад үзвэл Монголбанкийг хүнд байдалд оруулчихаж байгаа юм. Инфляцийг хязгаарлах Сангийн бодлогоор дамжаад нийт эрэлтийг хэт их тэлж байгаа учраас үнийн өсөлт бий болсон. Тиймээс бодлогын хүүг чангаруулахаас аргагүй байдалд орж байна. Нэгэнт төсвийн өндөр тэлэлттэй байгаа нөхцөлд цаашид үнийн өсөлт буурна гэсэн хүлээлт тун бага байгаа юм. Тийм учраас мөнгөний бодлого үүгээр зогсохгүй, цаашаа хатуурч магадгүй. Өнөөгийн түвшинд аваад үзвэл мөнгөний нийлүүлэлтийн өсөлт харьцангуй гайгүй байна. Одоогийн үнийн өсөлтийн томоохон шалтгаан нь төсвийн тэлэлт. Төсвийн тэлэлт агшиж өгөхгүй бол үнийн өсөлт цаашид өөдрөг харагдахгүй.

2. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2013 оноос бүрэн хэрэгжинэ. Тиймээс бид энд тодорхой хамгаалалт үүсэх бололцоотой. Бодит өсөлтөө аваад үзэхэд эдийн засаг асар хурдацтай тэлж байгаа нь үнэн. Гэхдээ сувгаа сайн ойлгох хэрэгтэй. Бодлогын хүү ямар сувгаар инфляцид нөлөөлөөд байгаа юм бэ. Ихэнх хүмүүс үүнийг ойлгохгүйгээсээ болоод ташаа дүгнэлтэд хүрчихээд байна. Одоогийн мөнгөний бодлогоор дамжуулан авч буй арга хэмжээ бол сонгодог арга. Үеэ өнгөрөөсөн арга биш. Үүнтэй бол санал нийлэхгүй байна.

Харин зохистой харьцааны үзүүлэлтээр дамжуулан мөнгөний нийлүүлэлт, мөнгөний бодлогоо явуулах боломжтой. Мөнгөний бодлогыг үгүйсгэж, өөр байх ёстой гэж үзээд байгаа хүмүүс нь түүнийгээ тайлбарлах ёстой. Ямар бодлого, арга хэрэгсэл санал болгож буйгаа тодорхой хэлэх хэрэгтэй. Мөнгөний бодлого дээр сонголт маш тодорхой. Шууд ба шууд бус арга хэрэгсэл байдаг. Нэг бол зохистой харьцааны хэрэгслүүд байна. Зохистой харьцааны хэрэгслүүд нь эдийн засгийн дархлаажуулалт, төрөлжилтөд сайнаар нөлөөлж магадгүй хэдий ч энэ арга манайд судлагдаагүй. Одоогоор энэ хоёроос өөр сонголт байхгүй.

3. Эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, хямралын үед Засгийн газарт Төвбанк санхүүжилт олгох боломжтойгоор зохицуулсан байгаа. Өнөөдрийн байдлаар хүндрэлд орсон юм алга. Ийм байхад Төвбанк зээл өгсөн нь буруу үйлдэл. Засгийн газар Монголбанкны хараат бус байдалд шууд халдсан. Энэ бол ухралт. Төвбанкнаас Засгийн газарт санхүүжилт олгодог байдал цаашдаа бүрмөсөн алга болох ёстой. Төвбанкны хараат бус байдлыг чандлан сахих хэрэгтэй.

4. Засгийн газрын төсвийн тэлэлт, эдийн засгийн өсөлтөө дагаад Төвбанкны тодорхойлж байгаагаар инфляци нэг оронтой тоонд байх боломж бага харагдана. Бүр айхтар өсөөд явчих байдал бас харагдахгүй байна. Өмнөх жилийнхээ түвшинд байх болов уу гэж хүлээж байна. Сонгуультай холбоотойгоор инфляци өсөхгүй болов уу. Яагаад гэвэл, сонгуулийг дайруулж, төсөвт тэтгэлэгт хөтөлбөрийн зардлаа суулгаад зарцуулагдаад эхэлсэн учраас нөлөөлөл бага. Инфляцийн тооцоонд хэдийнэ орчихсон байх талтай. Харин үүнээс давсан, шинэ нийгмийн арга хэмжээнүүд төсвийн тодотгол маягаар ороод ирвэл инфляци цаашид өсч болох талтай. ■

Ч.ОТГОЧУЛУУГИЙН БУЛАН

“ТӨВ”-ГҮЙ ТӨВБАНК



Физикт “таталцлын хүч” гэсэн ойлголт байдаг. Сар дэлхийг тойрон эргэдэг шиг, дэлхий нарыг тойрч эргэнэ. Хүнээс үл хамааран татах хүч оршин байдгийг физикчид таталцлын хууль гэж нэрлэдэг. Хэрэв энэ хүч оршин байгаагүй бол дэлхий дээр амьдрал байхгүй байсан гэдэг нь ойлгомжтой. Энэ бодит үзэгдлийг шинжлэх ухаанд оруулж ирэн, хүн төрөлхтөнд цэгцтэй танин мэдэхүйн мэдлэг өгөхөд Ньютон тэргүүтэй физикчид их хувь нэмэр оруулсан. Сансарт пуужин, хиймэл дагуул сэлт хөөргөж бас буулгаж эхэлсэн нь хүн энэ хүчийг зөвхөн танин мэдээд зогсохгүй улмаар өөрсдийнхөө амьдралд ашиглаж эхэлсний жишээ юм. Таталцлын хүч зогслоо гэж хийсвэрлэн төсөөлөхөд агаар, ус бүх юм хязгааргүй уудам огторгуй руу жингүйдэн алга болно. Хүн ч мөн адил. Огторгуй эсвэл байгалийн энэ хууль агуу. Тэд бидний ахуйн оршихуйг хангаж байдаг.

Эдийн засагт “мөнгөнд шунах шунал” гэсэн нэг ойлголт байна. Үүнийг үзэл суртал, гоо зүйн үүднээс “ашгийн төлөө” хэмээн цэвэрхэн томьёолдог. Орчин цагын хүн сайхан амьдрахын тулд мөнгөтэй байх хэрэгтэй. Мөнгө олохын тулд бизнес хийдэг. Мөнгөний татах хүч нь чөлөөт зах зээлийг улмаар үндэсний баялгийг бүрдүүлдэг гээд Адам Смит тэргүүтэй эдийн засагчид онолддог билээ. Хэрэв мөнгө үнэ цэнээ алдвал, дэлхийн татах хүч гэнэт зогссонтой адил аюул учрахгүй, өөрөөр хэлбэл бүх зүйлс сансарт цацагдахгүй. Гэвч мөнгө үнээ цэнээ алдсанаар эдийн засаг хямарч, ажилгүйдэл, ядуурал улмаар дарангуйлал гэсэн нийгмийн үр дагаврууд бий болно. Яагаад нийгмийн гэвэл, хүн дүрст мичний сүрэг эсвэл таван хошуу малын маань дунд иймэрхүү үзэгдэл үгүй. Энэ үзэгдлийг эдийн засгийн шинжлэх ухаан судалдаг.

Мөнгө гэж ер нь юу вэ? Гүн ухаантнууд, яруу найрагчид мөнгийг ад чөтгөрийн тараасан хөзрөөс эхлээд амьдрал мөнгөн дээр тогтдог гэхчилэн түмэн янзаар тодорхойлох байх. Харин эдийн засагчдын хувьд мөнгө бол солилцооны хэрэгсэл. Хэрвээ мөнгө байгаагүй бол бид малаар бүх хэрэгтэй юмаа солих байсан. Энэ бол өртөг зардал асар ихтэй үйлдэл. Жишээ нь хоньчин эр сэтгүүл авч уншихаар бол нэг хонио сэтгүүлчид аваачиж өгнө. Сэтгүүлч надад хонь хэрэггүй гутал хэрэгтэй гэвэл, гуталчин дээр очно. Энэ мэт эцэс төгсгөлгүй үргэлжлэх боломжтой. Мөнгөний өөр нэг хүч нь өртгийг хадгалж байдаг. Долоон буудлын Должин эмээ 1000 төгрөгтэй бол хоёр сонголт байна. Өнөөдөр нэг литр сүү худалдаж аваад ууна. Эсвэл хадгалж байгаад сарын дараа сүү авч ууна. Мөнгийг буюу 1000 төгрөгийг нэг сар, нэг жил хадгалж болно, харин шинэ сүүг хэцүү. Мөнгө өөр олон гайхалтай чанартай. Гэвч энэ удаад зөвхөн энэ хоёр чанараар нь зогсоё.

Өнөөдрийн Монгол Улсын албан ёсны мөнгөн тэмдэгт төгрөг юм. Социализмын сүүлийн жилүүдэд монгол төгрөг дэлхийн хамгийн чанга ханштай мөнгөн тэмдэгт байлаа. Өөрөөр хэлбэл, нэг ам.доллар албан ёсоор гурван төгрөг байж. Дээр нь шилжих рубль гэгч нь улс төржсөн, эдийн засгийн агуулгаас хол мөн л их хатуу ханштай байж. Эдгээр зохиомол ханшийн үр дүнд манай экспортын чадвар буурч, бас өнөө алдарт “их өр” үндэслэлгүйгээр өсч байсан гэж би хувьдаа боддог. Бодит баялаг үйлдвэрлэж байсан “Эрдэнэт”, “Говь” зэрэг компани яагаад хүссэн үр дүнг үзүүлэхгүй байсан нь ханшийн зохиомол бодлоготой холбоотой гэж санадаг. Гэвч энэ талаар хийсэн дорвитой судалгааг олж үзээгүй л байна. Ямартай ч тухайн үеийн Төвбанк ЗХУ-аас, дотроо МАХН-аас асар их хараат байсан нь тодорхой.

Өнөөдрийн Монголбанк ямар ажиллаж байна вэ? Лав арилжааны хэдэн банкуудынхаа төв болж чадаад байх шиг байна. Гэхдээ албан хүчээр, хуулийн дарангуйллаар. Тэрнээс биш үлгэр дууриал, манлайлал, харилцан ойлголцол энэ тэр тал дээр юу л бол.

Монголбанк сүүлийн жилүүдэд том орнуудын төв банкыг дууриаж инфляцийг онилно гэх боллоо. Гэвч инфляцийг онилдог орнуудад Төвбанкны бие даасан байдал болон нэр хүнд асар өндөр байдаг. Төвбанкны Ерөнхийлөгч нар нь онол, практикийн зэргэн туршлагатай, мөн нийтийн хүлээлтийг удирдахын тулд байнга шахуу хэвлэлийнхэнтэй үгээр “дайтаж” буй харагддаг.

Төвбанкны оршихуйн хууль юу вэ? Дэлхий дээрх амьдралыг таталцлын хууль тэтгэж байдаг гэдгийг шинжлэх ухаан нээсэн. Тэгвэл хүний бүтээл болсон Төв банкыг ямар хүч тэтгэж байдаг юм болоо. Энэ хүч буюу улс төрд уусан замхрахаас нь сэргийлж татаж байдаг тэр бодит “Төв” юу байж болох вэ? Энэ бол мөнгө хэмээх ард түмний өмчийг хамгаалах үүрэг юм.

Төвбанк- мөнгөний үнэ цэнийн манаач байх ёстой. Мөнгийг үнэгүйдэхээс, улс төрийн сонгууль хэмээх хар нүх рүү сорогдон одохоос сэргийлж татдаг байх ёстой.

Энэ нь Төвбанкны төв юм.

Гэвч өнөөдөр байдал ямар байна вэ? Инфляци 15 хувьд хүрчихсэн явна. Төвбанк бодлогын хүүгээ нэмлээ. Үр дүнд нь ажлын байр бий болгодог компаниуд хохироод үлдэнэ, цалингаас цалингийн хооронд банкны зээлээр амьдардаг иргэд, эсвэл орон сууцны зээлийн дор махийж буй залуу хосуудын санхүүгийн дарамт өсөх болно.

Төвбанк мэдээж бурууг Сангийн яам, УИХ, намууд руу чихнэ. Түүнээс гадна Төвбанкны үүрэг нь өөрөө тодорхойгүй байдлыг бий болгодог. Төв банкны тухай хуулийн 4-р зүйлд "Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино" хэмээн хуульчилсан байдаг. Гэтэл тогтвортой байдал гэдэг нь өөрөө юу юм бэ гэдэг нь тодорхойгүй. Тодорхойгүй үүргийг хангана гэдэг боломжгүй.

Аливаа орны мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал нь түүний ханшийг тогтвортой байлгана гэсэн үг юм. Мөнгөн тэмдэгт нь дотоод ба гадаад гэсэн хоёр ханштай байдаг. Мөнгөний дотоод ханш бол худалдан авах чадвар. Энэ жил нэг литр сүүтэй тэнцэж буй 1000 төгрөг ирэх жилд мөн адил нэг литр сүүтэй тэнцэнэ гэдэг баталгаа юм. Үүний дайсан бол инфляци. Гадаад ханш нь валют. Нэг ам.доллартай хэдэн төгрөг харьцаж байна гэдгээр тодорхойлогдоно.

Тогтвортой байдал хэр хэмжээнд, ямар хуга-цаанд хэлбэлзэхийг хэлж буй нь тодорхойгүй. Ханш сарын дотор хэдэн хувь хэлбэлзэхэд, хэдэн хувиар унахад, инфляци хэдэн хувьтай байхад тогтвортой, эсвэл тогтворгүй байна гэж үзэх нь ойлгомжгүй.

Эдийн засгийн орчинг амжилттай бүрдүүлээд байгаа улс орнуудыг харахад мөнгөний бодлого нь их цэгцтэй байдаг. Аль ханшаа хамгаалах гээд байгаа нь тодорхой. Хоёр ханшийг хамтад нь хамгаалдаг нь ерөнхийдөө ховор. Монголбанк инфляци өндөр байгаад Сангийн яамыг буруутгадаг. Сангийн яам болохоор бид ямар мөнгө хэвлэж байгаа биш, Монголбанк бодлогоо хэрэгжүүлж чадахгүй байна гээд нэгнийгээ буруутгаад эхэлдэг. Үр дүнд нь инфляци гаарсаар.

Ямартай ч эдийн засаг ч тэр, физик ч тэр адилхан л шинжлэх ухаан хойно ямар нэг төв цэгээс эхлээд тайлбар, гаргалгаагаа хийгээд явдаг. Зарчим бол ижил.

Харин Монголын хувьд номоороо бус, урсгалаараа явж буй олон зүйлийн нэг нь манай Төвбанк ба түүний тухай хууль юм. Төвбанкны төв нь уг нь ард түмний өмч болсон мөнгөний үнэ цэнийн тогтвортой байдал юм. Гэвч улс төрийн огторгуй руу сарниж одоод буй нь татах "Төв"-гүй болсныг нь илтгэх мэт. ■

ТӨСӨВ

БОДЛОГЫН ХҮҮ ЗАСГИЙН БОДЛОГЫГ БУТ НИРГЭСЭН ҮҮ

Төсвөөс жилдээ 12 орчим тэрбум төгрөгийг Төрийн банкинд төлнө гэсэн үг. Энэхүү хөрөнгө нь төсвийн нийт зардлын 0.28 хувийг эзлэх аж.

Б.АЛТАЙ

Яагаад...

Инфляцийн хурдыг сааруулахын тулд Төвбанк мөнгөний бодлогыг чангаруулсаар буй нь Засгийн газрын нэр хүндэд сөрөг PR болчихлоо. Учир нь, Засгийн газраас хэрэгжүүлж буй, хамгийн амжилттай, ард түмний талархлыг хүлээсэн "100 мянган орон сууц" хөтөлбөр саарах шинжиндээ оржээ.

Тус хөтөлбөрийн санхүүжилтийг 400 тэрбум төгрөгөөр тооцон тал хувийг нь Хөгжлийн банкнаас, үлдсэнийг нь арилжааны банкны өөрийн хөрөнгөөс татаас өгөх байдлаар гаргахаар төлөвлөжээ. Гэтэл Монголбанк бодлогын хүүгээ 13.25 хувьд хүргэсэн нь дээрх тооцоог эвдсэн байна. Арилжааны банкууд есөн хувиар татсан эх үүсвэрээ 12 хувиар зээлдүүлж, төрөөс зургаан хувийн татаас авахаар Засгийн газартай тохиролцсон боловч цаг үеийн шаардлагаар бий болсон 13.25 хувийн өндөр хүүтэй, богино хугацааны баталгаатай Төвбанкны үнэт цаас дээрх төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлцлийг үгүйсгэхэд хүргэжээ.

Өөрөөр хэлбэл, арилжааны банкуудын хувьд Засгийн газраас зургаан хувийн татаас авахаас илүүтэйгээр 13.25 хувийн хүүтэй Монголбанкны үнэт цаасыг анхны харцаар шохоорхох нь ашигтай. Дээр нь банкуудын дүрмийн санг нэмэгдүүлэх шийдвэр ч нэрмээс болсон байна. Ямар ч тохиолдолд Төвбанкны дээрх үнэт цаас арилжааны банкинд ашигтай болохыг Сангийн яамны мэргэжилтнүүд хүлээн зөвшөөрч байна.

Харин орон сууцжуулах хөтөлбөрт "Капитал", "Чингис хаан", "Төрийн банк" оролцох санал ирүүлжээ. Одоогийн байдлаар "Төрийн банк" орон сууцны нэгдсэн зээлийг



ФОТОГ Ү.ОДБАЯР

хэрэгжүүлж байна. Нэг банкаар зээлийг дамжуулах нь урсгал зардал буурах, төсөвт өгөх дарамт багасна гэж Сангийн яамнаас үзжээ.

Ар талын “фронт” хаачив?

Монголбанкнаас гадаад валюттай харьцах төгрөгийн ханшид ирэх дарамтыг бууруулах, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогын хүүг чангаруулж, арилжааны банкуудад тааламжтай орчин бүрдүүлсэн. Төвбанкны үнэт цаасны хүүгээр ашиг хийх боломжийг арилжааны банкууд эдлэхийн зэрэгцээ Засгийн газарт бүсээ чангалахыг сануулаа. Өөрөөр хэлбэл, “100 мянган айл орон сууц” хөтөлбөрт оролцож, ар талын хүчтэй “фронт” байхаа амласан банкныхан баяртай ч гэж хэлж чадалгүй Засгийн газрыг умартав. Ёстой л хаврын хуйсгануур цаг агаар шиг байлаа, тэд. Улс төрийн орчин ч сонгуулийн шинж чанартай болчихсон учраас арилжааны банкны эзэд Монголбанкинд итгэхээр шийджээ. Харин Засгийн газар “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийн хэдэн хувийг энэ онд хэрэгжүүлж чадах бол гэдэг сонирхолтой асуулт гарч ирлээ. Түүхэнд байгаагүй өндөр зарлагатай 2012 оны төсөвт арилжааны банкинд ногдох байсан ачааг үүрүүлэх үү. Төсвөөс хэчнээн төгрөгийг орон сууцны татаасанд “гулсуулах” вэ? Нийтдээ банкны системд 600 гаруй тэрбум төгрөгийн моргейжийн зээл байдаг аж. Тиймээс уг тоог энэ онд 230 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр Засгийн газар шуурхайлах янзтай.

Төрийн банк ашиггүй ажиллана

Хөгжлийн банкны 200 тэрбум төгрөгийн бондын эх үүсвэр л хамгийн баталгаатай алтан найдвар болж үлдэх нь. Арилжааны томоохон банкууд өөрийн эх үүсвэрээс орон сууцны хөтөлбөрт зээл олгох тухайгаа өнгөрсөн оны хавраас Сангийн яаманд мэдэгдсэн байна. Энэхүү мэдэгдлийг тус яамнаас олзуурхан хүлээн авсан боловч арилжааны банкууд Засгийн газарт “молиго үмхүүлсэн” хэрэг болжээ. Тиймээс Хөгжлийн банкны 200 тэрбум төгрөг дээр Төрийн банкны өөрийн хөрөнгийн 34 тэрбум төгрөгийг нэгтгэн нийт 234 тэрбум төгрөгийг “100 мянган айл орон сууц” хөтөлбөрт жилийн зургаан хувийн хүүтэйгээр олгож эхэллээ. Сангийн яамны тооцож байгаагаар дээрх хэмжээний төгрөгийг нэг зээлдэгчдэд 50 сая төгрөгөөр олгоно гэж тооцоход нийтдээ энэ онд 4680 айл шинэ орон сууцтай болох нь. Жилдээ 4680 айл орон сууцанд шилжих бол 21 жилийн дараа “100 мянган айл” хөтөлбөр зорилгоо бодитой биелүүлэх юм байна.

Улаанбаатар хотод барьж байгаа, энэ онд ашиглалтад орох 25 мянга орчим орон сууцнаас 17300 нь дээрх хөтөлбөрийн зорилтот зах зээл. Татаасын тухайд Төрийн банкинд 234 тэрбум төгрөгөөр тооцон, зургаан хувийн татаасыг олгох юм байна. Энэ нь төсвөөс жилдээ 12 орчим тэрбум төгрөгийг Төрийн банкинд төлнө гэсэн үг. Үлдэж буй хугацаанд долоон тэрбум төгрөгийг төсвөөс суутгах юм байна. Энэхүү хөрөнгө нь төсвийн нийт зардлын 0.28 хувийг эзлэх аж.

“Төсөвт учруулах дарамтын хувьд их биш ч Төрийн банкыг ашиггүй ажиллахад хүргэнэ” хэмээн Сангийн яамнаас мэдэгдлээ. Харин эдийн засагч Б.Төвшинтөгс “Төрийн банк төрийн хэрэгжүүлэгч агентлаг юм уу. Зах зээлийн ямар ч эрүүл өрсөлдөөн алга. Нэг талаасаа Төрийн банк давуу эрх эдэлж байна” гэв.

Бага хүүтэй, урт хугацаатай, чанартай орон сууцанд амьдрах нь гэр хороололд амьдарч буй мянга мянган хүний өрхийн гишүүдийн өдрийн бодол, шөнийн зүүд. Гэтэл хүсэлд хясал их ээ. Нийлүүлэлт нь жилдээ 10 мянгаар хэмжигдэж байхад “100 мянган орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зөв үү. Эрэлт, нийлүүлэлт эн тэнцүү байвал үнэ тогтвортой байдаг шүү дээ. Хэрвээ инфляци өсөөгүй бол Монголбанк бодлогын хүүгээ нэмээгүй бол, УИХ энэ оны төсвийг тэлээгүй бол, Засгийн газар нийтийг хамарсан бэлэн мөнгөний халамжийг үзүүлээгүй бол орон сууцжуулах хөтөлбөр “од” болох байж. Арилжааны банкууд ч Засгийн газрын саналаас булталж, Төвбанкны үнэт цаасанд “дурлахгүй” байх байлаа. ■

ХУУЛЬ

ДАВХАР ТАТВАРЫН ГЭРЭЭНД “НО” ИХ

Уул уурхайн салбар манай эдийн засгийн зүтгүүр нь. Тэгвэл зүтгүүр болсон хөгжлийн галт тэрэг замын дундаа гацаж мэдэх нь. Гацах болсон шалтгаан нь гэрээний эрх зүйн орчин.

Б.БАЯРТОГТОХ




Уул уурхайн салбар манай эдийн засгийн зүтгүүр нь. Тэгвэл зүтгүүр болсон хөгжлийн галт тэрэг замын дундаа гацаж мэдэх нь. Гацах болсон шалтгаан нь гэрээний эрх зүйн орчин. Хөрөнгө оруулалтын гэрээний дараа эрэмблэгдэх Давхар татварын гэрээтэй холбоотой асуудлаас болоод Монгол Улс ашиггүй ажиллаж мэдэх нь. Улс орны гадаад худалдаа, эдийн засгийн аюулгүй байдлыг сахин хамгаалах тулгуур гэрээ нь Давхар татварын гэрээ аж. Манай улс гадаадын улс орнуудтай “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай гэрээ” буюу Давхар татварын гэрээг нийт 35 улстай байгуулсан юм байна. Одоогийн байдлаар 30 нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа аж. Давхар татварын 26 гэрээг 1991-1998 онд, 1999-2007 онд найман гэрээг баталсан байна. Үүнээс үзэхэд гэрээний 74 хувийг 1999 оноос өмнө буюу одоогоос 13-20 жилийн өмнө байгуулжээ. Тухайн үед манайх одоогийнх шиг дэлхий нийтийн анхааралд өртөж байсангүй. Тиймээс аль болох хөрөнгө оруулагчдыг өөртөө татах, хөрөнгийн урсгалыг Монгол руу чиглүүлэх гэж нээлттэй ханддаг байж. Өөрөөр хэлбэл, бодлогоор гадаадын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт эдлүүлэх найртай сайхан орчинг бүрдүүлж өгөхийн төлөө монголчууд ажиллаж байсан гэсэн үг. Тэр үед манай эдийн засагт өсөлт байсангүй. Гол тулгамдаж байсан зүйл нь гадаад харилцаагаа сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар эдийн засгаа хөгжүүлэх байсныг өнөөдөр учир мэдэх улс тайлбарлаж байна. Нөгөө талаар гэрээ хэлцэл байгуулах туршлага муутай, үр дагаврын талаар сайтар ойлголтгүй байсан тул Давхар татварын гэрээ байгуулах хүсэлт тавьсан ихэнх улстай, гэрээний заалтыг нарийн нягталж, судалж үзэлгүйгээр байгуулдаг байжээ. Ер нь хөгжиж буй болон хөгжилтэй улс орнуудын хооронд хийсэн Давхар татварын гэрээнээс хөгжилтэй улс нь илүү их өгөөж хүртэж, хөгжиж буй улсад бараг өгөөж хүртэхгүй байх нь элбэг байдаг юм байна. Тиймээс Давхар татварын гэрээ эргээд

улс орныхоо эдийн засагт цохилт өгөх сул талтай байдаг аж.

Цохилт 1

Монгол Улсыг ашигтай ажиллахыг эрмэлзсэн нэгэн компанитай зүйрлэж болох юм. Тийм болохоор бүхий л зардлаа нөхөж, хэзээд ашиг, орлоготой байхыг хүссэн эзэнтэй. Гэтэл замын дундаас ашиг орлогыг нь булаах гэсэн, зах зээлээс шахах өрсөлдөгч, хууль бус хөндлөнгийн “гар” ороод ирвэл яах вэ? Ийм асуудалтай монголчууд өнөөдөр нүүр тулан мэгдэж сууна. “Далааraа тавиулна” гэдэгчлэн гэнэтийн цохилт ирж байна. Тиймээс өөрсдийн хүртэх ашиг, орлогоо хамгаалахын тулд хариу үйлдэл үзүүлэх нь мэдээж хэрэг. Ямар ч улс орон, компани өөрийн бүтээгдэхүүнээсээ ашиг л хардаг. Түүнээс биш, ашиггүй, алдагдалтай ажиллахыг хэн хүсэх билээ. Зах зээл ч үүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Гэтэл зах зээлийг нь булаах гэж буй томоохон үндэстэн дамнасан компаниуд татварын дотоодын хууль тогтоомж болон тухайн улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээрийг нарийвчлан судалж, тэдгээрийн хүрээнд яаж хамгийн бага татвар төлж болох гарц, хувилбарыг хайн олж, сул талаар нь тоглолт хийх гээд байвал яах вэ. Ийм тохиолдолд улс орнууд хоорондоо байгуулсан Давхар татварын гэрээгээ сөхөн хардаг байна. “Манайхаас бусад улс оронтой байгуулсан Давхар татварын гэрээ хэлцлүүдийг НҮБ, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгуулага /ЭЗХАХБ/-ын гэрээний загварууд, мөн Монгол Улстай хөгжлийн түвшин ойролцоо буюу доогуур зарим улсын (Филиппин, Гана) Давхар татварын гэрээнүүдтэй харьцуулж үзэхэд, манайх маш муу гэрээ хэлцлүүдийг хийсэн” гэж Сангийн яамны Төсвийн бодлогын газрын Орлогын хэлтсийн дарга Ж.Ганбат хэллээ.



Эх сурвалж. АМГ

Цохилт 2

Давхар татварын гэрээний улмаас үүсч буй асуудлууд Сангийн яамны толгойны өвчин болжээ. Ингэж хэлэх нэг бус шалтгаан бий. Одоо үйлчилж буй давхар татварын гэрээний заалтын улмаас Монгол Улсаас эх үүсвэртэй зарим орлогоос манай улс татвар авах боломжгүй байгаа нь асуудал үүсгэжээ. Тухайлбал, Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу оршин суугч бус татвар төлөгчийн ногдол ашгийн орлогоос 20 хувийн татвар суутган авахаар байдаг. Гэтэл Монголоос бусад улстай байгуулсан Давхар татварын гэрээ хэлцлээр ганцхан улсаас 15, (Энэтхэг), 10-аад улсаас 10 хувиар, дөрвөн улсаас бүр огт татвар авахгүйгээр зохицуулагдсан байх жишээтэй. Мөн манай Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу оршин суугч бус татвар төлөгчийн эрхийн шимтгэлийн орлогоос 20 хувийн татвар суутган авахаар байдаг. Тэгвэл дээрх гэрээ хэлцлээр ганцхан улсаас 20 (ОХУ), 10-аад улсаас 10 хувиар, мөн мөн тооны улсаас таван хувиар албан татвар авах зохицуулалттай байна. Бас нэг гайхмаар асуудал энд бий. Давхар татварын гэрээг дагалдан хийсэн протоколд заасны дагуу Щвейцарь улсаас огт татвар авахгүйгээр зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, монголчууд гадаадын хөрөнгө оруулагчдыг дэндүү эрх чөлөөтэй, дур зоргоороо “амьдрах” боломжийг гэрээгээрээ дамжуулан олгожээ гэсэн үг.

Цохилт 3

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 25-нд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр оршин суугч бус татвар төлөгчийн Монгол Улсаас эх үүсвэртэйгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос 20 хувийн татвар суутган авахаар болсон. Гэтэл Канад, Хойд Солонгос, Энэтхэг, Итали, Люксембург, Малайз, Нидерланд гэсэн долоон улстай байгуулсан Давхар татварын гэрээ хэлэлцээрт техникийн үйлчилгээний төлбөрөөс манайх татвар авах эрхтэй. Харин бусад улсаас манайх техникийн үйлчилгээний төлбөрөөс татвар суутган авч чадахгүй болжээ.

Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу оршин суугч бус татвар төлөгчийн хүүгийн орлогоос 20 хувийн татвар суутган авахаар байдаг. Гэтэл Бельги, Франц, Люксембург, Нидерланд болон Щвейцарь улстай байгуулсан Давхар татварын гэрээгээр банк буюу санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн орлогод, Кувейт болон Арабын нэгдсэн эмират улстай байгуулсан гэрээгээр бүх төрлийн хүүгийн орлогод Монгол Улсад татвар ногдуулахгүй байх заалттай ажээ. Нэг үгээр хэлбэл, Давхар татварын гэрээнд “но” их бий гэсэн үг. Энэ талаар Дэлхийн худалдааны байгууллагад зарга мэдүүлж болох талтай гэнэ.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд л “Саусгоби сэндс” компанитай холбоотойгоор Монгол Улсын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар ашигт малтмалын ордыг шилжүүлэх үйл явц болон тэдгээрээс татвар авах асуудлыг шийдвэрлэсэн ч Канад улстай байгуулсан Давхар татварын гэрээний 13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу Монгол Улс татвар ногдуулах боломжгүй байна. Канад улстай байгуулсан Давхар татварын гэрээний 13 дугаар

бүлэгт Монгол Улсад байрлалтай үл хөдлөх хөрөнгөтэй шууд буюу шууд бус замаар хамааралтай хувьцааг борлуулсны олзоос Монгол Улс татвар авахаар заасан хэдий ч уг заалтыг хэрэгжүүлэхдээ “үл хөдлөх хөрөнгө” гэдэг үйл ажиллагаанд ашиглагдаж буй түрээсийн хөрөнгөөс бусад аливаа хөрөнгийг хамаарахгүй байхаар заасны улмаас дээрх төрлийн хувьцаа борлуулсны олзоос Монгол Улс татвар авч чадахгүйд хүрч байна. Иймд Канад улстай байгуулсан Давхар татварын гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай болж байна. Энэ тухай www.iltod.gov.mn цахим хуудсанд тэмдэглэжээ.

Цохилт 4


Давхар татварын гэрээний сул талуудыг ашиглан гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд Нидерланд, Люксембург зэрэг улсад толгой компаниа бүртгүүлэх замаар Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, татвараас зайлсхийх нь түгээмэл байдаг аж. 1999-2010 оны хооронд манай улсад орж ирсэн шууд хөрөнгө оруулалтын 27 хувь нь зөвхөн Нидерланд улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээс орж ирсэн мэдээ бий. Гадаадын хөрөнгө оруулалтын газраас гаргасан мэдээгээр Нидерланд улсаас манай улсад 2010 онд 232.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж иржээ. Ашигт малтмалын газраас авсан мэдээллээр Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар хайгуулын болон ашиглалтын нийт 23502 тусгай зөвшөөрөл олгосон байгаа аж. Нийт тусгай зөвшөөрлийн 6125 нь буюу 26 хувийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд эзэмшдэг. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын дотор Нидерландад 80, Люксембургт дөрвөн лицензтустусэзэмшиж байна. Энэхүү нөхцөл байдлын улмаас Монгол Улс их хэмжээний татварын орлогыг гадаадын улс орнуудад алдаж байгаа бөгөөд гэрээ хэлцлийг нэг бүрчлэн засч залруулна гэвэл маш их хугацаа, хүч хөдөлмөр шаардлагатай аж. Тухайлбал, Нидерланд, Люксембург улстай байгуулсан Давхар татварын гэрээ хэлцлийг өөрчлөх ажлыг Сангийн яамны зүгээс жил гаруйн өмнөөс эхлүүлж, удаа дараа нөгөө талд хүсэлт тавьжээ. Хэрвээ манай хүсэлтийг хүлээн авахгүй бол дангаар цуцлах болно гэж мэдэгдсэний дараа нөгөө талаас дахин хэлэлцээр хийх саналыг хүлээн зөвшөөрчээ. Хэдийгээр манай улс давхар татварын зарим гэрээ хэлцлээ өөрчилж сайжруулсан ч Давхар татварын гэрээ хэлцэлтэй бусад улс орон руу толгой компаниа шилжүүлэх замаар (treaty shopping) Монгол Улсад татвар төлөхөөс зайлсхийх процесс байх эрсдэл байсаар байж магадгүй нь.



ФОТОГ Б.БЯМБА-ОЧИР

Боломж

“Манайх татварын хууль тогтоомжоо дотооддоо хэдий сайн шинэчлэн сайжруулсан ч олон сул талтай одоогийн Давхар татварын гэрээ хэлцлүүд гаднын компаниудын хооронд хийх өндөр дүнтэй ажил гүйлгээнээс татвар авах бололцоонд хаалт болсоор байх юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу оршин суугч бус татвар төлөгчийн ногдол ашгийн орлого, эрхийн шимтгэлийн орлого, Монгол Улсаас эх үүсвэртэйгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлого, хүүгийн



орлогоос 20 хувийн татвар суутган авах ёстой. Гэтэл давхар татварын гэрээтэй 30 гаруй улсын ихэнхээс нь татвар авахааргүй байдлаар гэрээтэй байна" гэж Сангийн яамын Төсвийн бодлогын газрын дарга Б.Батжаргал ярив. Сангийн яамны зүгээс Давхар татварын бүх гэрээг цуцлах хуулийн төслийг бэлтгээд буй бөгөөд холбогдох яамдад санал хүргүүлжээ. Давхар татварын гэрээг бүгдийг цуцлаад, дотоодын татварын хууль тогтоомжидоо шинэчлэлт хийсний дараа Давхар татварын шинэчилсэн гэрээний загвартай нийцсэн гэрээ хэлцлийг бусад улстай байгуулахад нээлттэй гэдгээ дипломат шугамаар мэдэгдэж болно гэж Сангийн яам үзэж байгаа аж.

Давхар татварын цоорхойтой хуулийг яаран засаж сайжруулахгүй аваас уул уурхайн салбар ид хүчээ авч эхлэх үед Монгол Улс зохих хэмжээнд татварын орлогоо цуглуулж чадахгүйд хүрэхээр байгаа ба энэ нь улс орны хөгжилд сөргөөр нөлөөлөхийг Б.Батжаргал учирласан юм.

Сангийн яам болон Үндэсний татварын ерөнхий газар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэж дуусаад буй. Уг шинэчилсэн найруулгад Монгол Улсад хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн (дээд шатны компанийг оролцуулан) хувьцааны 10-аас дээш хувийг борлуулсан тохиолдолд хувьцаа борлуулсны олзыг Монгол Улсаас эх үүсвэртэй орлого гэж үзэж, Монгол Улс татвар авах зохицуулалтыг оруулжээ. Нэг үгээр хэлбэл, хэн хаанаас, хэний баялгаар ашиг олно. Тухайн ашигтай ажилласан компани, иргэн татвараа тухайн улсдаа төлнө гэсэн үг. "Орлого хаанаас олно. Тухайн орлогын эх үүсвэр байгаа улс оронд татвар төлөх нь Давхар татварын гэрээний мөн чанар гэж үзэж болох. Тухайлбал, Хятадын хөрөнгө оруулалттай компани Монголын газар нутагт үйл ажиллагаа явуулж, ашиг хүртэж байгаа бол манайд татвараа төлөх нь гарцаагүй. Уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж, томоохон төсөл арга хэмжээ хэрэгжиж, үндэстэн дамнасан компаниуд Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй энэ үед уг асуудлыг яаралтай засаж сайжруулах нь зүйн хэрэг.

Гарц:

Уг нь Ерөнхий сайд С.Батболд өнгөрсөн оны аравдугаар сард 2012 оны төсвийн төслийг УИХ-д өргөн барих үеэр хэлсэн үгэндээ давхар татварын бүх гэрээг эргэн харах, өөрчлөх, улс орны эрх ашигт хохиролтой гэж үзвэл зарим гэрээг цуцлах хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар ажиллаж байгаа талаар онцолсон удаатай. Давхар татварын гэрээнүүдийг УИХ-аас 2012 он хоёрдугаар улиралд цуцалж, энэ талаар нөгөө талд ирэх зургадугаар сарын 30-наас өмнө дипломат шугамаар мэдэгдэл хүргүүлснээр гэрээнүүд 2013 оноос эхлэн хүчин төгөлдөр бус болох гарц харагдаж байгаа аж. Давхар татварын гэрээг алдаатай хийж байгуулсны улмаас улс орны татварын орлогод асар их хохирол учирч, гэрээг нэг тал дангаар цуцалж байсан гадаад орны зарим жишээ бий. Тухайлбал, 2008 оны зургадугаар сарын 30-нд Аргентин улс Австри улстай байгуулсан Давхар татварын гэрээгээ дангаар цуцалжээ. Хэдийгээр тус хоёр улсын хөрөнгө оруулагчид энэ шийдвэрийг тун тааламжгүйгээр хүлээн авсан ч дээрх гэрээний заалтын улмаас Аргентини улс Австрийн бондын хүүгийн орлогоос татвар авч чадахгүй байна гэсэн үндэслэлээр гэрээг дангаар цуцалж байжээ.

Мөн 1987 оны зургадугаар сарын 29-нд АНУ-ын Төрийн сангийн газар АНУ-Нидерланд улсын хооронд байгуулсан Давхар татварын гэрээг дангаар цуцалсан байна. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийх замаар асуудлыг шийдвэрлэхээр хоёр улс найман жилийн турш хичээсэн хэдий ч Нидерланд татварын диваажин гэсэн статустаа өөрчлөлт оруулахыг хүсээгүй тул гэрээг нэг тал дангаар цуцалснаар асуудал дуусгавар болжээ. Гэрээг дуусгавар болгосноор гэрээг гуравдагч тал урвуулан ашиглах явдал үгүй болж АНУ-ын хувьд том ялалт болж байжээ. ■

ЗЭЭЛ

ЛИЗИНГ ЭДИЙН ЗАСГИЙГ ДООШ ЧАНГААЖ, ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛД СААД БОЛЖ БАЙНА

Манайхан хэрэглээнд ихээхэн анхаарал хандуулдаг. Хэрэглээг шүтсэн орон хэрхэн хямардгийг Грек, Испанийн өнөөгийн хямрал харуулж байна.



Л.ОЮУН /МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор/

Зээл болгон нийгэм эдийн засгийн нэг асуудлыг шийдвэрлэдэг, шийдвэрлэж байх ч ёстой. Тухайлбал, орон сууцны зээл нь хүмүүсийн тав тухтай амьдралын орчныг бүрдүүлэх зориулалттай бөгөөд манай орны хувьд утааны асуудлыг шийдвэрлэх гол арга зам нь болох жишээтэй. Арилжааны банкны зээлүүд дотроос хэрэглээний зээлийн тухай дэлгэрэнгүй авч үзье.

Хэрэглээний зээл гэж юу вэ?

Хэрэглээний зээл гэдэг нь хэрэглээний эд зүйлсийг худалдан авахад зориулагддаг. Манайд хэрэглээний эд зүйлсийг компьютер, угаалгын машин, телевизор цаашилбал автомашин зэргийг банкны хэрэглээний зээлээр ялангуяа лизингээр авдаг. Лизингийн зээлийн мөн чанар нь тоног төхөөрөмжийг худалдан авахад олгодог зээлийг хэлдэг. Ийм зориулалтаар олгосон зээл нь орлого бүтээнэ. Тоног төхөөрөмжийн үнэ маш өндөр байдаг тул үйлдвэрлэл явуулахад нь дэмжлэг үзүүлэх зориулалтаар лизингийн зээл олгодог. Гэтэл манай банкууд хэрэглээний эд зүйлсийн зээлийг лизинг гэж нэрлэж байгаа нь буруу юм.


Хэрэглээний эд зүйлсийг лизингээр олгодоггүй. Лизингийн мөн чанарыг дараах жишээгээр тайлбарлаж болох юм. Угаалгын машиныг хэн нэгэн жишээ нь үсчин үйлчилгээндээ зориулж зээлээр авч байгаа бол лизинг гэж нэрлэж болно. Харин гэртээ хэрэглэхээр зориулж зээлээр авч байгаа бол энэ лизинг байх боломжгүй. Эхний тохиолдолд угаалгын машин үсчинг орлого олоход нь хэрэглэж байгаа бол хоёр дахь тохиолдолд угаалгын машин шууд утгаараа орлого бүтээхгүй. Хэрэглээнд зориулж зээлээр авсан угаалгын машины үнэ нь зээлийн хүүний хэмжээгээр өснө. Ингээд хэрэглээний өртгийг нэмэгдүүлж байна гэсэн үг.

Аливаа зээл нь орлого бүтээх зориулалтай. Харин хэрэглээний зээл нь орлого бүтээдэггүйгээрээ бусад зээлээс ялгаатай.

Манайхан хэрэглээнд ихээхэн анхаарал хандуулдаг. Хэрэглээг шүтсэн орон хэрхэн хямардгийг Грек, Испанийн өнөөгийн хямрал харуулна. Өөрөөр хэлбэл, хэрэглээний зээл монголчуудын зан авирийг илэрхийлж байна гэж үзэж болно. Монголчууд хуримтлалгүй ард түмэн. Нэг ёсондоо хэрэглээг шүтэж ирсэн. Хэрэглээ эдийн засгийн өсөлтийг үндэслэж байдаг тухай “Кейнсын хэрэглээний онол” бий. Барааны борлуулалт нэмэгдэхийн хэрээр үйлдвэрлэл хөгждөг. “Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийнэ” гэж ярьдаг даа. Энэ нь эдийн

Хэрэглээний зээлийн харьцуулалт

		Хугацаа	Хэмжээ	Хүү /сарын/
Голомт банк		3-18 сар	3 сая төгрөг хүртэл	2.0%
Хаан банк	Автомашин болон мотоциклын хэрэглээний лизинг	36 хүртлэх сар	30 сая төгрөг хүртэл	1.5-1.9%
	Цахилгаан бараа болон гэр ахуйн тавилга	24 хүртлэх сар	5 сая төгрөг хүртэл	1.5-1.9%
Капитал банк		24 хүртлэх сар	25 сая төгрөг хүртэл	1.7-2.3%
Кредит банк		3-24 хүртлэх сар	1-50 сая төгрөг хүртэл	1.83%
Эрэл банк		3-12 хүртлэх сар	Хэрэглээнд шаардагдах хөрөнгө	2.8%



Шог зургийг А.Амарсайхан

засгийн утгаараа орлогынхоо хүрээнд хэрэглэх, тэгснээрээ өрөнд орохгүй байх, хуримтлалтай болох, хэмнэх санааг агуулж байна. Хэрэглээний эд зүйлсийг зээлээр авснаар түүний үнийг өсгөж хэрэглэж байна гэсэн үг. Монголчуудын хэрэглээг чухалчилдаг гэдгийг мэдэх учир худалдааны байгууллагынхан өөрсдийн барааг лизингээр борлуулах нь их болсон. Үүнд нь банк нэмэр өгч нэг ёсондоо өөгшүүлж байна. Одоо Монголд ялангуяа хот суурин газар лизингээр хэрэглээний зүйл аваагүй айл өрх бараг байхгүй байх гэж хэлж болно.

Лизингийн хэрэглээний зээлээр дотоодод үйлдвэрлэсэн барааны борлуулалтыг дэмжиж байгаа бол өөр хэрэг. Гэтэл Монголд үйлдвэрлэдэггүй бараануудыг лизингийн хэлбэрээр зарж байгаа нь манай эдийн засгийг доош чангааж, үндэсний үйлдвэрлэл хөгжихэд саад болж байна.

Арилжааны банкуудын олгож буй зээлийн багцад хэрэглээний зээлийн эзлэх хувийн жин бага биш байгаа нь сайн үзүүлэлт биш гэж бодож байна. Тэдний олгож байгаа цалингийн, тэтгэврийн, хадгаламж барьцаалсан зээлүүд нь хэрэглээний эд зүйлс авахад л зориулагддаг нь тодорхой. Зарим банкны олгож буй хэрэглээний зээлийн нөхцөлийг дээрх хүснэгтээс харж болно.

Хүснэгтээс харахад зээлийн хэмжээ бага (1-5 сая төгрөг), автомашины зээл нь 25-50 сая төгрөг байгаа нь зээлдэгчдийг ашиггүй зүйлд түлхсэн, орлого бүтээхгүй хэрэглээнд дасгаж байгаа гэсэн үг. Хэрэглээний зээлийн хүү нь бусад зээлтэй харьцуулахад өндөр, хугацаа нь богино байгаа нь иргэдийг зээлийн дарамтад оруулах магадлалыг бүрдүүлж байна.

Зээл, түүний зарчим

Орлого бүтээх ямарваа нэг үйл ажиллагааг санхүүжүүлэх хамгийн хүртээмжтэй, түгээмэл эх үүсвэр нь зээл. Банкны зээл бизнесийн санхүүжилтэд аль ч оронд хамгийн их хувийг эзэлдэг.


Үнэт цаасны зах зээл нь өндөр хөгжсөн оронд ч банкны зээл санхүүжилтийн өндөр хувийг эзэлдэг. Манай орны хувьд үнэт цаасны зах зээлийн хөгжил сул, банк нь санхүүгийн зах зээл дээрх активын 95 хувийг эзэлдэг тул зээл нь санхүүжилтийн гол хэлбэр болдог. Зээл нь банкны зүгээс харилцагч, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээс тодорхой зориулалтаар хүү, хугацаатай, барьцаа батлан даалттайгаар өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд олгож байгаа мөнгөн хөрөнгө юм. Зээл нь зээлдэгч үйл ажиллагаа өргөжүүлэх, хөгжүүлэхэд зориулж авч байгаа хөрөнгө бөгөөд гол нь орлого бүтээх зориулалтаар олгогддог. Ингэснээр зээл эргэн төлөгдөх баталгаа нь болдог. Зээл төлөх эх үүсвэр нь зээлийн мөнгөөр олсон ашиг байх зарчим үйлчилдэг юм.■

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭН “ҮЙЛДВЭРЛЭГЧ” МОНГОЛ

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад хүүхэддээ гэр бүлийн хүмүүжлээр болон цэцэрлэг, бага, дунд ангийн хичээлийн хөтөлбөрөөр нь дамжуулж мөнгөтэй харилцах, санхүүгийн боловсрол олгох хичээлийг олгож, амьдралын хэвшил болгож өгдөг ажээ.

Хүний амьдралын санхүүгийн мөчлөг



13-17 Хүүхэд нас

18-24 Ахлах сургууль, оюутан

25-34 Гэр бүлтэй болох

35-44 Албан тушаал ахих

45-54 Тэтгэвэрт гарах төлөвлөгөө зохиох

55-64 Тэтгэвэрт тарах



Хүний амьдралын санхүүгийн мөчлөгийн онолыг 1950-1960-аад онд эдийн засагч Franco Modigliani болон Richard Brumberg нар гаргасан байна.

Эх сурвалж: “Төгс шийдэл” судалгааны компани Санхүүгийн боловсролын хичээлийн хэсгээс

Б.УУГАНБАЯР

Дэлхийн ихэнх оронд иргэд нь элбэг хангалуун амьдрахын тулд хуримтлал үүсгэдэг. Харин манай монголчууд хуримтлуулж чаддаггүй. Хуримтлалд төдийлэн ач холбогдол өгөлгүй өнөөдрийг хүрсэн улс. Эдийн засаг хөгжихийн хэрээр монголчуудад оройтсон ч гэсэн хуримтлалтай болохыг цаг үе шаардаж байна. Хувь хүн төдийгүй улс нь хүртэл хэцүү цагт аваад хэрэглэх хойшоо хийсэн мөнгөтэй суухгүй бол уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах, дэлхийн эдийн засаг ханиад хүрэхэд л Монгол Улс яаж балрах аюултайг 2008-2009 онд хангалттай мэдэрсэн, манайхан. Гэхдээ улс баян байхын тулд иргэн баян байх ёстой гэдгийг цаг хугацаа бидэнд илүү мэдрүүлж байна. Нэг үгээр хэлбэл, Та эх орныхоо хөгжилд дэм болохын тулд хувь хүний хуримтлалыг бий болгох ёстой гэсэн үг.

“Хүн өөрийн хэрэглээнээс илүү гарсан орлогоо цуглуулж, байшин, машин худалдаж авах, суралцах гэх мэт хэрэгтэй зүйлдээ хөрөнгө оруулалт хийхийг зорьдог. Манай улсын хувьд мөн адил Тогтворжуулалтын санг үүсгэж хуримтлал үүсгэж эхэлж байгаа. “Япон, Солонгос гэх мэт оронд иргэд нь маш их хэмжээний мөнгийг банкинд байршуулж, хуримтлуулсан байдаг. Энэ нь арилжааны банкаараа дамжаад улсын чанартай томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санхүүгийн эх үүсвэр болж байгаа юм. Тэгэхээр хуримтлал энэ утгаараа улсын эдийн засагт өндөр ач холбогдолтой” хэмээн эдийн засагч Н.Дашзэвэг бичжээ. Харин манай улсын хувьд иргэд хангалттай цалингүй, зарим нь орлогогүй ядуу учраас хуримтлал үүсгэж чадахгүй байна. Тэгэхээр төр, засгийн зүгээс аль болох хуримтлалыг дэмжсэн бодлого явуулах хэрэгтэй гэдгийг ч тэрбээр хэлсэн. Тэгвэл нөгөө талаас энэ нь нэг талаараа бодлогын түвшинд өөрчлөлт хийх ёстойг шаардаж байгаа ч иргэд үүнтэй эвлэрч, ядуу амьдралтайгаа эвлэрэх ёсгүй гэж хэлэх хүн ч цөөнгүй. Энэ талаар Банк санхүүгийн академийн гүйцэтгэх захирал С.Нэргүй “Хүн хоол идэж, өмсөж зүүж амьдарч л буй бол цалин, тэтгэвэр, халамж гээд ямар нэг хэлбэрээр орлоготой байгаа. Тийм ээс ядуу гэлтгүй хүн бүхэнд бүсээ чангалж, олсон орлогынхоо ядаж 10 хувийг ирээдүйнхээ төлөө хадгалах боломжтой” гэдгийг хэлсэн.

Цалинтай оюутнуудын тансаглал

Өнөөдөр монголчууд Хүний хөгжлийн 21, оюутны 70 мянга, гурван хүүхэд төрүүлсэн эхэд олгох нэг удаагийн 300 мянга, Алдарт эхийн одонтой эхчүүдийн нэг сая төгрөг гээд хөгшин, хөвөөгүй гар дээрээ бэлэн

мөнгө авч буй. Бага гэлтгүй орлогоосоо тодорхой хэсгийг нь цаашаа хийж хуримтлуулах боломж уг нь хүн бүрт бий. Гэвч бэлэн мөнгөний далайд умбасан монголчууд хуримтлал үүсгэж байгаа нь юу л бол. Олонхи нь зүгээр орж ирж байгаа мөнгийг хэрэглээндээ л зарцуулаад дуусгая хэмээн гарынхаа салаагаар урсгадаг байх гэж таамаглахад хэтрүүлэг болохгүй болов уу. Тухайлбал, оюутнууд сар бүр 70,000 төгрөгийн цалинтай. Тэдний нэг хэсэг нь аав, ээжээсээ мөнгө авахгүйгээр цалингийнхаа хэдэн хувийг нь хоол унд, унааны зардал, хичээл номдоо зарцуулах вэ, хэдэн хувийг нь цаашаа хийж, ирэх жилийн сургалтын төлбөртөө нэмэрлэх вэ гэдэг талаар төлөвлөж тооцоотой зарцуулдаг л байх. Гэхдээ ийм оюутан тун цөөхөн. Харин олонхи нь мөнөөх л монголчуудын мөнгөнд тооцоотой биш зангаар замнадаг нь тодорхой. Үүнийг гэрчлэх нэгэн жишээг цухас сонирхуулъя. Саяхан амралтын өдөр манай хэдэн найзууд уулзахаар боллоо. Эхлээд ресторанд орж хооллож, баахан буу халж сууцгаав. Хэдийнэ 22.00 цаг болсон байв. Нэг зав гаргасных жаахан бүжиглэхээр шийдлээ. Тэгээд хаашаа явцгаах вэ болж, удтал ярилцаж байгаад залуучуудын орох дуртай газрын нэг “Доргио” шөнийн клубт очлоо. Цагийн зүү 24.00 цаг руу дөхөх тусам шөнийн клубийн бүх ширээ нь пиг дүүрч, бүжгийн талбай нь ч хөл гишгэх зайгүй шахам болов. Үйлчлүүлэгчийн ихэнх нь оюутнууд. Бүжиглэхэд зориулж гангарч, гоодож ирсэн охидууд орж ирэнгүүтээ шууд л “Болор”, “Хар чингис” мэтийн үнэтэй сархад лонхоор нь, 2-3 литрийн савтай жүүсний хамт захиалж авах аж. Үйлчлэгч шилтэй цэнхрийн бөглөөг онгойлгонгуут нэг нэг 100 грамм татангуутаа нэг стакан жүүсээр даруулж хөнтөрчихөөд, бүжгийн талбайд гарах нь тэр.

Манай найзууд оюутны ширээнээс хөндийрөөд нэг их удаагүй ч тэднийг хараад “Пөөх, оюутнууд чинь ийм аймаар болчихсон юм уу” гэж өөрийн эрхгүй гайхацгаасан. Нэг найз маань “Тэгэлгүй яах вэ, цалинтай хүмүүс чинь ингэж тансаглалгүй дээ” гэж егөөдөв.

“Аав ээж нар нь 70,000 төгрөгөө ингэж дэмий үрдгийг нь мэдэхгүй байгаа даа. Ялангуяа хөдөө байдаг эцэг эх 70,000 төгрөг охиныг нь “архичин” болгож байгаа гэж огт төсөөлөхгүй шүү дээ. Камераар бичлэг хийгээд, эцэг эхэд нь үзүүлэх юмсан” гэж хүртэл нэг маань санаашрав. Төр оюутнуудыг биш, баар, рестораны газрын бизнес, архи, шар айрагны үйлдвэрлэл, импортыг л ийн дэмжиж байх шиг. 21 мянга ч ялгаагүй олон архичдын “хоолыг” бэлддэг талаар иргэд ярьдаг. Ямар ч өртөг шингээхгүй халамжийн мөнгийг иргэд нь иймэрхүү байдлаар л хайр гамгүй урсгаж байна.



Хас банкнаас санаачлан хүүхдэд нийгэм, санхүүгийн боловсрол олгохоор хэрэгжүүлж буй “Афлатон” хөтөлбөрийн оролцогч Б.Бадамчулуун багштай 48 дугаар сургуулийн 5д ангийнхан

ФОТОГ Э.ЗОРИГТ

Мөнгө хуримтлуулах биш, үрэх аргыг заагчид

Монголчууд хэзээ хуримтлуулж сурна даа гэж санаашрах бодол төрөх. “Бид ч өнгөрсөн. Ирээдүй хойч маань л харин мөнгөний үнэ цэнийг мэдэрсэн, өвдөж зовохдоо хэрэглэнэ гээд мөнгө цаашаа хийдэг байгаасай гэж бодох хүн ч бий. Тэгвэл бидний хүсээд байгаа ирээдүй маань багаасаа мөнгөний гахайтай найзалж өсөж чадах болов уу. Одоогийн хариуцлагагүй, мөнгөний үнэ цэнийг муу мэдэрдэг аав, ээжүүд хүүхдээ хурааж хуримтлуулах ухамсар, хүмүүжлийг суулгаж чадна гэж шууд хэлэхэд бэрхтэй л байна.

Учир нь, ихэнх аав, ээжүүд бололцоотой ч бай, бололцоо тааруутай ч бай хүүхдээ хар багаас нь мөнгөөр угждаг муу зуршилтай. Угжина гэдэг нь бөөн бөөн мөнгө өгч байгаа гэсэн санаа биш л дээ. Нэгдүгээр ангид явдаг хүүхдийнхээ халаасанд өглөө бүр бололцоо тааруутай нь дунджаар 500 төгрөг, дундаж амьдралтай нь 1000 төгрөг, бололцоотой нь 2000-3000 төгрөг хийж эрхлүүлэх нь энүүхэнд. Үнэхээр хүүхэд нь хоол унданд зориулдаг бол болно. Гэвч өгсөн мөнгийг юунд хэрхэн зарцуулж байна гэсэн хяналтыг эцэг эх тэр бүр тавиад байж чаддаггүй.

Цэцэрлэгийн насны хүүхэдтэй зарим эцэг эх өглөө бүр зам дагуух дэлгүүр, ТҮЦ орж, ундаа жүүс, модтой чихэр, жигнэмэг зэргийг авч өгч, хичээлд нь оруулж харагддаг. Бяцхан үрээ “Битгий ээжийгээ дагаарай. Багшийнхаа заасан зүйлийг сайн сураад, цэцэрлэгтээ томоотой байгаарай” гэж захиж, шагнаж байгаа нь энэ. Муу занд сурсан жаал өглөөд мөнөөх дэлгүүр рүүгээ орж, ямар нэг зүйл авахуулахгүй л бол санаа нь амрахгүй. Эцэг эх нь өөрсдөө эхлээд ийм буруу зуршилд уруу татсан болохоор хүслээр нь болохгүй гээд яалтай. Зөвхөн цэцэрлэгт нь өгөхийн тулд дор хаяж өдөрт хүүхдэдээ 500-1000 төгрөг зарцуулдаг гэж тооцоолоход хэдий хэмжээний мөнгө гарах бол. Гэтэл их бага нь хамаагүй өдөр бүр хүүхдийнхээ данс руу 1500-2000 төгрөг хийгээд байвал цэцэрлэгийн бэлтгэл ангиа дүүргэхэд нь хэд болж өссөн байх вэ гэж бодож үзсэн үү? Эцэг эхийн хүүхдээ хуурахын тулд авч өгч байгаа хүнс нь хоол болохоосоо илүүтэй хор болох нь элбэг. Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд шүдний өвчлөл газар авсныг “Эрүүл монгол хүүхэд” аяны эмч нар зурагтаар байнга ярих боллоо. Үүнд томчууд буруутай.

Сайн эхлэл

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад хүүхэддээ гэр бүлийн хүмүүжлээр болон цэцэрлэг, бага, дунд ангийн хичээлийн хөтөлбөрөөр нь дамжуулж мөнгөтэй харилцах, санхүүгийн боловсрол олгох хичээлийг олгож, амьдралын хэвшил болгон өгдөг ажээ. Гэтэл манайд энэ тогтолцоо байхгүй учраас бид дэлхийн бусад орны иргэдээс хөгжлийн хувьд дутуу нэг ёсондоо “хөгжлийн бэрхшээлтэй иргэн” үйлдвэрлэж байгаа гэдгийг Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал М.Болд шүүмжилсэн юм. Түүнчлэн оюуны болон санхүүгийн хувьд иргэд ядуу байх тусам улс орны хөгжил, иргэний эдийн засагт оруулах хувь нэмэр үгүй бөгөөд харин ч хойш чангаасаар байдаг аж.

Тэгэхээр санхүүгийн боловсролтой шинэ үеийн иргэдийг төлөвшүүлэн гаргах нөгөө талаас иргэдэд хуримтлал бий болгох боломж нөхцөлийг төр, засгийн зүгээс хууль эрх зүйн хүрээнд дэмжих гэсэн хоёр гарц байна. Үүний сайн эхлэл бол “Тэмүүлэл”, “Афлатон” санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрт улсын хэмжээний ерөнхий боловсролын 120 орчим сургуулийн 25 мянган хүүхдийг хамруулж буй явдал юм.

Бид сайн үйлсийг дэмжин дэлгэрүүлэх зорилгоор санхүүгийн боловсрол хөтөлбөрт хамрагдаж буй нийслэлийн зарим сургуулийн сурагчдын төлөөлөлтэй уулзаж, энэ төрлийн хичээлд нь ч сууж сонирхлоо. “Аав ээжүүд хүүхдээ хүссэн зүйлийг нь авч өгөхөөс биш, мөнгийг яаж хөдөлмөрлөж, хөлсөө дуслуулан олдог талаараа огт хэлдэггүй. Дээр нь хүүхэд маань авсан мөнгөө юунд зарцуулж байна гэж хяналт тавьдаггүй нь буруу санагддаг” хэмээн “Тэмүүлэл” санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн оролцогч 14 дүгээр сургуулийн 9ж ангийн сурагч Х.Энхсаруул хэлсэн. Тэрбээр Энхсаруул охин амьдралын их далайд хөл тавихаасаа өмнө мөнгөний үнэ цэнийг мэдэрч, яагаад зөвхөн хэрэгтэй зүйлдээ л зарцуулах ёстой, үлдсэн мөнгөө хуримтлуулж, ирээдүйнхээ мөрөөдөлд хүрэх хэрэгсэл болгон ашиглах ёстойг сайн ойлгожээ. Энхсаруул эцэг эхээсээ мөнгө авч, дэмий үрэхээ больсон шалтгаан нь тэдний сургууль дээр хэрэгжсэн санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийн үр дүн аж. Ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчдын тав шахам хувь нь ч гэсэн санхүүгийн талаар ийм мэдлэг ойлголттой болно гэдэг сайн хэрэг.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлж буй “Хөгжлийн алтан сан” төрийн бус байгууллагын зүгээс санхүүгийн хичээлийг ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт албан ёсоор оруулах хүсэлтэй буйгаа холбогдох газруудад нэг бус удаа танилцуулж, тавьж байгаа ч төдийлэн дэмжлэг авахгүй байгаа нь хачирхалтай.

Монгол хүн бүр 1072 хувьцаа эзэмшигч болсон, хүн бүр гардээрээ бэлэн мөнгө авч байгаатай холбоотойгоор хүүхэд багачуудад одооноос санхүүгийн боловсрол олгох зайлшгүй шаардлага бий. Энэ талаар БСШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын дарга Д.Эрдэнчимэгээс лавлахад “Энэ чиглэлийн хөтөлбөрийг шууд тусгах боломжгүй. Харин Бизнес судлалын хичээлд ерөнхий агуулгыг оруулахаар судалж байгаа” гэв.

Ирээдүйд “Хөгжлийн бэрхшээлтэй” иргэн үйлдвэрлэдэг Монгол биш, эх орны хөгжилд хувь нэмэр оруулж чадах иргэнийг бий болгох нь үнэхээрийн чухал байна. ■

ТАЙЛАН

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ШААРДАЖ БАЙНА



ЯАН ХАНСЭН /АХБ-ны Суурийн төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч/

Нийгмийн халамж, цалин, бэлэн мөнгө олголт нэмэгдэхийн хэрээр төсвийн зарцуулалт өнгөрсөн онд 55.6 хувиар нэмэгдэж, ДНБ-ий 44.2 хувийг эзлэх хэмжээнд хүрчээ. Монголбанк мөнгөний бодлогыг 2010 оны эхнээс нэлээд чангатгасан хэдий ч инфляци энэ оны гуравдугаар сарын байдлаар 15.3 хувьд хүрээд байгаа бөгөөд дараагийн хоёр жилд хоёр оронтой тоонд байх төлөвтэй.

Монгол Улсын эдийн засаг эрчимтэй өсч байгаа ч төсвийн бодлого нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах болон бүх монгол хүнд хүртээмжтэй урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгцээг зохистойгоор тэнцвэржүүлэхэд чиглэсэн байх ёстой.

Өнгөрсөн сарын 11-нд гаргасан “Азийн хөгжлийн төлөв- 2012” тайланд Монголын эдийн засаг уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлийн үр дүнд энэ онд 15 хувь, 2013 онд 17.5 хувиар өснө гэж тооцоолжээ. Гэвч Монголын эдийн засаг нь түүхий эдийн үнийн хэлбэлзэл, олон улсын санхүүгийн зах зээл дэх өөрчлөлтөөс нэн их хамааралтай хэвээр байна.

ДНБ өнгөрсөн онд 17.3 хувиар өссөн. Эдийн засгийн өсөлт уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой дэд бүтцийн зарцуулалтаар өдөөгдсөн. Тоног төхөөрөмж, барилга байгууламж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, нийтийн эзэмшлийн дэд бүтэц зэргийг оруулаад нийт хуримтлалын 60 хувьд бодит өсөлт гарчээ. Оюутолгойн зэс, алтны уурхайн эхний шатны хөрөнгө оруулалт нийтдээ таван тэрбум ам.долларт хүрэх тооцоотой байгаа бөгөөд уурхай ашиглалтад орох хугацаа ойртсоор.

Өнгөрсөн оны хувьд эдийн засгийн бас нэг чухал хөтлөгч нь дотоодын хэрэглээ буюу төрийн болон хувийн хэрэглээ байсан бөгөөд бодит өсөлт нь 15 орчим хувь хүрчээ. Гадаад худалдаа өнгөрсөн онд үсрэнгүй нэмэгдэв. Хятад улсын эрэлтээс үүдсэн нүүрс үйлдвэрлэлийн хэмжээ болон нийт үнийн дүн нэмэгдсэнээр экспорт 64.4 хувиар өссөн байна. Нөгөө талаас импорт хоёр гаруй дахин нэмэгдсэн бөгөөд энэ нь уул уурхайн салбарын машин, тоног төхөөрөмжийн хэрэгцээ өссөнтэй холбоотой. Цэвэр экспорт хасах дүнтэй гарч буй тул үндэсний эдийн засгийн нийт өсөлтөд сөргөөр нөлөөлсөн.

ДНБ-ий өсөлтөд үзүүлсэн нөлөө /эрэлт/


Эдийн засгийн өсөлтийн ихэнх хувь хэмжээ уул уурхайн салбараас үүдэлтэй боловч, суурь нь чамгүй өргөжив. Нийт иргэдэд олгосон бэлэн мөнгө дотоод худалдаанд (бөөний болон жижиглэн) дэмжлэг болсноор энэ салбарт 42.5 хувийн өсөлт гарчээ. Уул уурхай болон боловсруулах үйлдвэрлэл тус бүр 8.7- 16.0 хувь өссөн бол барилгын салбар 14.3 хувь өсчээ. Нийт хүн амын гуравны нэгээс илүү хувь нь ажилладаг хөдөө аж ахуйн салбарт харин дорвитой өсөлт гараагүй байна.


Байгалийн нөөцийн ашиглалтыг хурдацтай, эрчимтэй хөгжүүлснээр макро эдийн засгийн удирдлагыг инфляцийн дарамт ихсэх, дотоодын валютын ханш чангарах, хувийн хэвшлийн бусад салбарыг шахах, гадаад хүчин зүйлд хэт өртөмтгий болгодог “Голланд өвчин” хэмээн нэрлэдэг үзэгдэл рүү хөтлөх нь элбэг байдаг. Монгол Улсад байгалийн нөөц баялгийн салбарыг байгаль орчинд ээлтэй, тэгш шударга арга замаар хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байр бий болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэнд, боловсрол, орон сууц, цэвэр, бохир усан хангамж зэрэг зайлшгүй хэрэгцээг хангах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд үлэмж хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтыг дэд бүтцэд зарцуулах шаардлагатай.

Гэхдээ төсвийн хэт их тэлэлт, тэр дундаа Хүний хөгжлийн сангаас нийт хүн амд хавтгайруулан олгож байгаа бэлэн мөнгө нь инфляцийн дарамтыг бий болгож, эдийн засгийг гаднын сөрөг нөлөөлөл, хэлбэлзэлд эмзэг мэдрэмтгий болгож байна. Нийгмийн халамж, цалин, бэлэн мөнгө олголт нэмэгдэхийн хэрээр төсвийн зарцуулалт 2011 онд 55.6 хувиар нэмэгдэж, ДНБ-ий 44.2 хувийг эзлэх хэмжээнд хүрчээ. Монголбанк мөнгөний бодлогыг 2010

оны эхнээс нэлээд чангатгасан хэдий ч инфляци энэ оны гуравдугаар сарын байдлаар 15.3 хувьд хүрээд байгаа бөгөөд дараагийн хоёр жилд хоёр оронтой тоонд байх төлөвтэй байна.

Төсвийн тогтвортой байдал болон макро эдийн засгийн тэнцвэрт сөргөөр нөлөөлөхгүйгээр нийгмийн гишүүн бүрт хүртээмжтэй өсөлтийг дэмжсэн төсвийн бодлого хэрэгжүүлэхийн тулд төсвийн зарлагыг урт





хугацааны хөрөнгө оруулалтад чиглүүлэх шаардлагатай байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бэлэн мөнгө хавтгайруулан олгох явдлыг халж, орлогыг орлуулан тооцох аргаар тодорхойлсон эмзэг буюу зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн бодлогыг нэвтрүүлсэн нь бага орлоготой иргэдийг үр дүнтэй дэмжих, төсөвт дарамт багатай нийгмийн хамгаалллын тогтолцоотой болох чиглэлд хийсэн томоохон алхам болов. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 оны зургадугаар сард, Төсвийн тухай хууль энэ оны эхэнд батлагдсанаар төрийн зүгээс сангийн бодлого мөн төсвийн удирдлагын хууль, эрх зүйн орчинг бэхжүүллээ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь уул уурхайгаас олсон орлогын удирдлагыг хэтдээ зохистой байлгах зорилгоор мөн төсвийн сахилгыг чангатгах үүднээс төсвийн алдагдал, төсвийн зардлын өсөлт болон (өр хэмжээ зэрэгт хязгаар тогтоосон гурван нэмэлт заалтыг нэвтрүүлсэн. Уг хуулийг хэрэгжүүлж, даган мөрдөх явдал нь төсвийн бодлогыг түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамгаалах, эрдсийн үйлдвэрлэлийн өсөлтийн эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад үнэтэй хувь нэмэр оруулах юм. Энэ нь мөн эрдсийн бус эдийн засгийн салбарын хөгжлийг дэмжих суурь болно.

Төсвийн тухай хууль нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтөөс эхлээд төсвийн гүйцэтгэл, аудитыг хамруулан төсвийн нийт үйл ажиллагаанд шинэчлэл хийхэд чиглэсэн өргөн хүрээг хамарсан хууль бөгөөд төсвийн төвлөрлийг сааруулах шинэ эрх зүйн орчныг бий болгож байна. Дээрх хоёр хуулийн үзэл санааг гуйвалтгүйгээр хэрэгжүүлэх нь нэн чухал байна.

Банкны салбар нь 2009 онд нүүрлэсэн санхүүгийн хямралаас хойш ихээхэн сэргэсэн билээ. Гэвч банкны зээл олголт өнгөрөгч гуравдугаар сарын байдлаар өмнөх жилээс 70 хувиар нэмэгдсэн нь эдийн засаг дахь эрэлтийг өдөөхийн зэрэгцээ банкны эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тиймээс Монголбанкны зүгээс банкуудын эрсдэлд чанд хяналт тавьж, журмаар тогтоож өгсөн зохистой харьцаа, шалгуур үзүүлэлтүүдийн хангалтыг хянаж байх нь нэн чухал.

Хачирхалтай нь байгалийн баялгийн арвин нөөц нь макро эдийн засгийн эмзэг өртөмтгий байдлыг нэмэгдүүлснээр урт хугацааны хөгжилд сөргөөр нөлөөлж, ингэснээрээ бодит салбар болон хүний хөгжилд хөрөнгө оруулалт хийх хөшүүргийг бууруулан, эдийн засаг болон улс төрийн институциудын чадамж, чадавхыг сулруулдгийг дэлхийн олон орны туршлага харуулж байна. Байгалийн баялгаас хамааралтай байх нь ихэвчлэн орлогын ялгаа гүнзгийрэхэд хүргэдэг. Учир нь, ашигт малтмалын олборлолт нь харьцангуй цөөн тооны ажлын байрыг бий болгон энэ ажлын байр дээр хүн амын багахан хэсэг нь ажиллаж орлогын дийлэнхийг олдогт байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад орлогын тэгш бус байдал, ялгаа нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь яваандаа нийгмийн тогтвортой байдал, уялдаа холбоог алдагдуулахад хүргэж болзошгүй. Монголд уул уурхайн салбар экспортын 90, төсвийн орлогын 30 болон ДНБ-ий 20 хувийг бүрдүүлж байгаа хэдий ч нийт ажлын байрны 1.6 хувийг бий болгов.

МонголУлсынхувьддундхугацаанд шийдэх ёстой тулгамдсан хоёр асуудал байна. Нэгдүгээрт, байгалийн баялгаас олсон орлогын ил тод, найдвартай, зөв, шударга удирдлагыг хангах зорилгоор эдийн засаг болон улс төрийн институтиуцуудыг улам бэхжүүлэх, хоёрдугаарт, эрдсийн бус салбаруудад хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих замаар ажлын байрыг бий болгох, эдийн засгийг олон талт болгох зэрэг явдал юм.

Азийн хөгжлийн банк (АХБ) нь 67 гишүүн орон бүхий олон талт хөгжлийн банк. Гишүүн орнуудын дунд 48 нь тус бүс нутгийн, 19 нь дэлхийн бусад бүс нутгийнх байдаг. АХБ нь сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсад хөгжлийн санхүүжилтийг хамгийн их олгосон байгууллага бөгөөд хөдөө аж ахуй, боловсрол, эрчим хүч, санхүү, эрүүл мэнд, аж үйлдвэр, харилцаа холбоо, тээвэр, хот байгуулалтын төслүүдэд санхүү болон техникийн туслалцаа үзүүлж ирсэн билээ. ■

НАСЖИЛТ

ЦЭЛИЙТЭЛ НЭЭГДСЭН ЦОНХЫГ ЗӨВ АШИГЛАЖ ЧАДАХ БОЛОВ УУ

ДЭМБ болон Зүүн бүсийн судалгааны багууд анхааруулахдаа “2050 онд Монгол Улсын таван хүн тутмын нэг нь өндөр настан, хоёр нь 0-5 насны хүүхэд байх болно. Өндөр настан, хоёр хүүхдүүдийн идэх хоол, амьдрах байр, ирээдүйн баталгаа, нийгмийн халамжийг дөнгөж 18-19 насны хоёр хүн үүрэх төлөвтэй байна” гэжээ.


Б.ЭНХМАРТ

Монгол хүний насжилтыг графикаас сонирхоорой. Графикийн шугам дээшээ тэмүүлсэн чигтэй байгаа нь сайн хэрэг. Энэ нь бидний аав ээж, эмээ өвөө, ахан дүүсийн нас уртсаж байгаа таатай мэдээ юм. Гэвч хэт олуулаа урт наслах нь сөрөг талтайг санахад илүүдэхгүй нь. Тухайн орны нийт хүн амын 12-оос дээш хувийг 60 ба түүнээс дээш насныхан эзэлбэл “хөгшин” улсын тоонд ордог байна. Үүний цаана бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлт, баялаг бүтээгч, техник, технологийн дэвшилд хөл нийлүүлэгчдийн тоо цөөрч, нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэндийн тусламж хүсэгч олширч, улсын эдийн засаг болоод аж үйлдвэрлэл уналтад орно гэсэн үг. Улмаар хөдөлмөрийн зах зээл болоод бусад үнэт зүйлээ харийн ажилчдад алддаг байна.

Энэ жил манай улс Дэлхийн эрүүл мэндийн өдрийг “Насжилт ба эрүүл мэнд” сэдвээр тэмдэглэж, 2012 оныг “Насжилттай тэмцэх жил” болгон зарласан. Энэ хүрээнд хийх ажлын нэг нь “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” хөтөлбөр боловсруулах аж. Энэ талаар тус хөтөлбөрийн удирдагч, Геронтологийн төвийн дарга, анагаах ухааны доктор Р.Оюунхандтай уулзлаа. Тэрбээр “Дундаж наслалтыг тухайн улсад төрж байгаа хүүхэд, нас баралтын харьцаагаар авч үздэг. Манай улсын хувьд 2000 оноос хойш төрөлт багасаж, наслалт уртсах байдал ажиглагдаж байна. Иймээс дундаж наслалтай орны тоонд багтлаа. Энэ нь ирээдүйд хөгшин орнуудын эгнээнд шилжихийн дохио юм. Амьдралын баталгаа сайжрах тусам хүний нас уртсаж, төрөлт багасдаг. Энэ хүрээнд бид “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” хөтөлбөрийг боловсруулж, батлуулахаар бэлтгэж байна. Энэ хөтөлбөр нь хүүхдийн тоог бодлогоор нэмэгдүүлэх, хөдөлмөрийн насны залуучуудын амьдралын баталгааг хангах, эрүүлжүүлэх, өндөр настнуудыг халамжлах, амьдралын чанарыг нь сайжруулах, насны гурван үечлэлийн аль алинийг эрүүл байлгахад чиглэх арга хэмжээ авах зорилготой юм” гэв. Насны гурван үечлэл нь хүүхэд эрүүл саруул бойжиж байж хөдөлмөрийн насанд үр бүтээлтэй ажиллана. Эрүүл, бүтээлч залуу боловсон хүчин ирээдүйн амьдралын баталгаатай өндөр настан болно гэж үздэг байна. Тиймээс Оюунханд эмч дээрх хөтөлбөртэй зорилго нэгтэй “Эрүүл хүүхэд” аянд идэвхтэй оролцохыг иргэдэд уриалав.

Хүн ам зүйн насжилтын асуудал XX зуунаасэхлэлтэй. Энэчиглэлээранх1982 онд НҮБ хуралдаж байсан бол үүнээс 20 жилийн дараа Испанийн Мадрид хотноо дэлхийн 156 орон хуралдаж, насжилт дэлхий нийтийн тулгамдсан асуудал болсныг зарлаж байжээ. Харин манайд 2009 онд “Хүн амын насжилтын асуудлын үндэсний стратеги”-ийг боловсруулан баталсан байна. Гэвч энэ үед манай улс хэдийнэ дундаж насжилттай орны тоонд багтсан байв. Одоо манай улсын нийт хүн амын 64.7 хувийг 25-50 насныхан буюу хөдөлмөрийн насны хүмүүс эзэлдэг. Үүнийг “Хүн амын цонх нээгдэх үе” гэж нэрлэдэг. Энэ нээгдсэн “цонх”-ыг зөв ашиглавал хөгжлийн хурдаа хэд дахин нэмж, улс орондоо үнэт зүйл төвлөрүүлж чаддаг байна.

Хүн амын нас хүйсийн суварга



Эх сурвалж: Геронтологийн төв

Хүүхдэдээ хүнд ачаа үүрүүлмээргүй байна

Хөгшин европ, барууны хөрөнгөтөн орнууд, Скандиновын орнууд, Япон, Солонгос, Австри, Итали, Франц одоогоос 80, 100 жилийн өмнө нээгдсэн хүн амын цонхоо сайтар ашиглаж баяжиж, хөрөнгөжсөн түүхтэй. Нээлттэй цонх гэдэг нь хөдөлмөрийн насны залуучууд нийт хүн амын тэн хагасаас илүү хувийг эзэлсэн он жилүүд. Өөрөөр хэлбэл, залуусын бүтээн байгуулалт хийх, дэлхийн зах зээлд өрсөлдөх үйлдвэрлэл, брэнд бий болгох орон зай юм.

Хөгшин гэгдэх дээрх орнууд хүн ам зүйн цонх нээгдсэн ийм үедээс идэр насны залуусаараа одоогийн мөнгө "хүүдийлэгч" аж үйлдвэрүүдийг босгосон гэдэг. Хүн амын цонх үе 20-30 жил үргэлжилдэг бөгөөд манай улсын хувьд 2000-2030 он энэ үед хамаарч байна. 2030 оноос "хөгшчүүл"-ийн тоо эрчимтэй нэмэгдэж, дараагийн 20 жилд идэвхжинэ хэмээн судлаачид үзэж буй. Тэр үед бид аж үйлдвэргүй, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул өнөөгийн хэдэн компанитайгаа байж байх вий. Ядаж хөгжингүй орны хөгшчүүл шиг тив дэлхийгээр аялж, зугаалаад явж чаддаггүй юм аа гэхэд, үр хүүхдээрээ хоолоо бэлдүүлэхгүй, өвчин эмгэггүй амьдарч байхыг хэн хүнгүй л хүсэх байх.

Уг нь бидний өмнө боломж цонхоо цэлийтэл нээчихээд байна. Ховорхон тохиох боломжийг хэр овжин ашиглах талаар бодож төлөвлөсөн ажил төр, засгийн хэмжээнд маруухан байгаа нь харамсалтай. Цонх нээгдсэнээс хойш хэдийнэ арав гаруй жил өнгөрчихсөн байгаа нь тоогүй. Зүгээр өнгөрүүлсэн арав гаруй жилийг ашигласан бол ихийг амжуулах байжээ. Гэвч манай үе үеийн төр, засгийнхан хүн амын насжилтын цонх нээгдсэн үеийг үл тоож ирсэн гэлтэй. Тухайлбал, хүн амын талаас илүү хувийг эзлэх хөдөлмөрийн насны иргэдээ яралзтал ажиллуулж, ид хавыг нь үзэхийн оронд хөгшин, хөвөөгүй хавтгайрсан халамжаар тэтгэж, залуусаа зүгээр сууж байгаад мөнгө авдаг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байгаа нь харамсалтай. Уул уурхайгаас орж ирж байгаа гэнэтийн их орлого насжилтын нээгдсэн цонхыг автоматоор хаачихаж ч мэдэх нөхцөл байдал үүсчээ. Учир нь, өнөөдөр барилга, авто зам, уул уурхай зэрэг бүтээн байгуулалтын салбарт хятад хүмүүсийг олноор нь авчирч, өндөр цалинтай ажиллуулж, эх орондоо хөдөлмөрлөх жинхэнэ эзэд нь 21 мянган төгрөгийн халамжид дугаарлаж, сар бүр банкны үүд сахин зогсоо. Энэ бол өнөөдрийн манай нийгмийн бодит төрх. Бид нээгдсэн цонхыг ийм маягаар өнгөрүүлэх юм бол 20 жилийн дараах эмээ, өвөө нарт халамж, үйлчилгээ үзүүлэх тухайн үеийн идэр насныхан дэндүү хүнд ачаа үүрнэ гэсэн үг аж.

Өөрөөр хэлбэл, өнөөдрийн 21 мянгад дугаарлаж зогсоо залуусыг хөгширсөн хойно нь өнөөдрийн хүн болох гэж хорвоод мэндэлж буй миний, таны нялх үрс тэжээнэ гэж ойлгож болно. Тэгэхээр төр, засгийн муугаас болж нээгдсэн цонхыг ашиглаагүй өнгөрөөсний төлөөсийг миний хүүхэд идэр насандаа нуруундаа ахадсан хүнд ачаа үүрэх ёстой юу. Тухайлбал, Үндэсний статистикийн газрын судалгаагаар 1970-аад оны дунд үед хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, ахмад настны тоо буюу хүн ам зүйн ачаалал гурав байсан бол 1990-ээд оны үед найм, 2008 онд 13 болсон бол хэтийн тооцоогоор 2025 онд 41 болох төлөвтэй байгаа аж.

ДЭМБ болон Зүүн бүсийн судалгааны багууд анхааруулахдаа "2050 онд Монгол Улсын таван хүн тутмын нэг нь өндөр настан, хоёр нь 0-5 насны хүүхэд байх болно. Өндөр настан, хоёр хүүхдүүдийн идэх хоол, амьдрах байр, ирээдүйн баталгаа, нийгмийн халамжийг дөнгөж 18-19 насны хоёр хүн үүрэх төлөвтэй байна" гэжээ. Тиймээс л бусад улс "цонх"-ыг нээгдэхийг анаж байгаад ашигладаг байна.

Монголчууд хөгширсөөр

Мөн "Цонх" үе буюу нөхөн үржихүйн идэвхтэй насны хүн амын тоо өндөр байх энэ үед зохистой төрөлтийг



дэмжих, насны бүтцийн тааламжтай өөрчлөлтийг эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан зохицуулах, тооны хувьд байнга өсөн нэмэгдэх ахмад настны эрүүл мэнд, аж байдлыг сайжруулахад онцгой анхаарах хэрэгтэйг "хөгшин" орнуудын туршлагаас харж болно.

Шинэ мянганы эхээр монгол хүний насны голч буюу нийт хүн амын тал хувийг 16-18 насны залуучууд эзэлж байсан бол арав гаруйхан жилийн дотор 22.5 болж нэмэгдэжээ. Энэ нь жил ирэх тусам монголчуудын насны голч "хөгширч" буйн илрэл юм. Монгол Улс хэдхэн жилийн дараа "хөгшин" гэж дуудуулах нь байна. Үүнээс сэргийлэх ямар ч арга байхгүй. Зогсоож чадсан түүх дэлхийд үгүй аж. Тиймээс ирээдүйн 20 жил бидний эрүүл мэнддээ анхаарах, үндэсний капиталаа бүтээх, хуримтлуулах он жилүүд байг. ■

ЕРТӨНЦӨӨР АЯЛАХУЙ

ОЧИР ЭРДЭНИЙН ХОТ

Бидний ихэнх нь Бельги улсыг НАТО болон Европын Холбооны төв гэж мэдэхээс цаашгүй. Тэгвэл дэлхийн хөрөнгийн биржийн төв болох Нью-Йорк хотыг үүсгэн байгуулсан бельгичүүдэд “томрох” олон брэнд бий. Цухасхан дурдахад дэлхийд хамгийн олон нэр төрлийн тоосго үйлдвэрлэдэг тус улс нь шоколадны үйлдвэрлэлээрээ дэлхийд манлайлагч. »



Б.ҮҮРИЙНТУЯА

“Дэлхийн унаа” хөлөглөж, европ брэндээр гангарч орон орны хоол зооглох нь даяарчлалын нэг шинж биш гэж үү. Парисийн Dior, Chanel, Louis Vuitton гээд брэндийн дэлгүүрүүдийг санагдуулам Улаанбаатарын нэг хэсэг байхад тансаг зоогийн газрууд, latte macchiato, cappuccino гээд Италийн дээд зэргийн кофе амтархаж болох “coffee shop”-уудаар гангарах өөр нэг хэсэг байх. Нийслэл маань дэлхийн хотуудын төв болжээ. Нэгэнт ийнхүү бодсоных дэлхийн төв гэхэд хэлсдэхгүй нэгэн улсын хөгжлөөс та бүхэнд сонирхуулъя.

Бидний ихэнх нь Бельги улсыг НАТО болон Европын Холбооны төв гэж мэдэхээс цаашгүй. Тэгвэл дэлхийн хөрөнгийн биржийн төв болох Нью-Йорк хотыг үүсгэн байгуулсан бельгичүүдэд “томрох” олон брэнд бий. Цухасхан дурдахад дэлхийд хамгийн олон нэр төрлийн тоосгыг үйлдвэрлэдэг тус улс нь шоколадны үйлдвэрлэлээрээ дэлхийд манлайлагч. Jean Neuhaus анх шоколадны нэг төрөл болох пралинь буюу элсэн чихрээр бүрсэн самрыг 1912 онд худалдаанд гаргаснаар Бельги шоколадны “эх орон” гэгдэх болсон. Дэлхийн брэнд болох Cote d’Or, Guylian, Neuhaus зэрэг шоколадыг амталж үзээгүй хүн ховор биз. Жилдээ 220 мянган тонн шоколад үйлдвэрлэдэг энэ улсыг өөр юу алдаршуулдаг бол...

Эрт үед, эдүгээ

Манай Улаанбаатар хотын нийт хүн амтай тэнцэхүйц иргэдтэй Антверпен хот нь Бельги улсынхаа “од” хотод тооцогддог. Бельгийг дэлхийн хамгийн үнэтэй бөгжтэй зүйрлэн бодвол энэ хот нь түүний таван кратын очир эрдэнэ л гэсэн үг.

1999 оны тэр нэгэн өдөр миний бие анх удаагаа Антверпен хотод хөл тавьж билээ. Дэлхийн хамгийн том галт тэрэгний буудлын нэг дээр ээжийгээ хүлээн зогсох тэр мөчөөс хойш эл хотод бүтэн найман жилийг өнгөрүүлсэн. Дундад зууны гэмээр, гэхдээ энэ нь дэлхийн хөгжлөөс хоцорсон гэсэн үг биш л дээ. Харин ч алхам бүрт түүх өгүүлэх барилгуудтай тус хотын тухай одоо бодоход, улсын хөгжил гэдэг зөвхөн тэнгэр баганадах шилэн барилга, хотын замд түгжрэх “Hummer” жийпны цуваа биш гэдгийг ойлгуулах шиг.

Антверпен хотын нэрийг “hand werpen” буюу “гар шидэх” гэсэн хоёр үгнээс гаралтай гэх таамаг бий. Эртний нэгэн домогт Шхелдь голын эрэг дагуу байрлах нэгэн хотод Антигон хэмээх



- Бельги улс нь дэлхийн хамгийн өндөр татвартай оронд тооцогддог. Тус улсын ДНБ-ий 45,6 хувийг орлогын татвар дангаараа бүрдүүлдэг.
- Бельги нь дэд бүтцээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг. Хурдны замын сүлжээг саран дээрээс харах боломжтой цорын ганц улс бөгөөд дэлхийн хамгийн урт трамбайн сүлжээ бүхий орон.
- Дэлхийн хамгийн олон эмэгтэй сайдтай Бельгийн аюулгүй байдлын төлөөлөгчид есөн удаа НҮБ-ийн Аюулгүй байдлын консулд сонгогдож байжээ.
- Бельгийн 11 сая хүн амын 1,6 сая нь буюу 15 хувь нь цагаач иргэд байдгаас 1000 гаруй нь монголчууд аж.
- Бельги улсын боловсролын салбар Европ тивдээ шилдэгт, харин дэлхийд 19 дүгээрт жагсдаг юм байна.
- Winsway Coking Coal Holding нүүрс олборлогч компанийн захирал Ванг Шингчун нь Сингапур гаралтай Бельгийн иргэн билээ. Тэрбээр Forbes сэтгүүлээс жил бүр тодруулдаг тэрбумтнуудын жагсаалтад 164 дүгээрт бичигддэг.

үлэмж биет амьдардаг байжээ. Тэрбээр гол гатлах гэж буй иргэдээс хураамж авдаг байсан бөгөөд татгалзсан нэгнийх нь баруун гарыг таслан голд хаядаг байж. Үүнд ард олон өширхөн, зэвүүцэв ч аварга биетэнтэй сөргөлдөх нь үгүй. Харин Брабо хэмээх залуу эр тэрхүү үлэмж биетний гарыг тасдан голын усанд шидсэн тэр цагаас Антверпен гэх нэрийг олсон гэдэг.

Дундад зууны үед Антверпен хот дэлхийд чухал усан боомтын нэг байсан учир Европын худалдаа, арилжааны төв болж байжээ. Элсэн чихэр, халуун ногоо, шанцай зэрэг тухайн үеийн тансаг хэрэглээний барааг худалдаалдаг байсан тус хотод XVI зууны эхэн үеэс өөр нэг чамин бүтээгдэхүүний худалдаа цэцэглэх болсон нь »



алмаазны үйлдвэрлэл байв. Португаль улсаас дүрвэсэн еврейчүүд тус хотод суурьшсан тэр цагаас “Очир эрдэнийн хот” гэх нэрийг зүүсэн Антверпен одоо ч дэлхийн очир алмаазны төв хэвээр.

Шигтгээ болох зам

Хамгийн анхны алмааз эрдэнийг 1476 онд Антверпен хотод зүсэн, боловсруулж байжээ. Тэр цагаас л хорвоогийн хамгийн үнэтэй эрдэнэс чулууг өнгөлөх, хэлбэрт оруулах шинэ технологийг нэвтрүүлсэн гэж үздэг. Дэлхийн боловсруулаагүй алмаазны 85, боловсруулсан алмаазны 50, үйлдвэрлэлийн зориулалтаар боловсруулсан алмаазны 40 хувь нь энд бий болдог. Энэ нь дэлхийн очир эрдэнийн худалдааны 90 хувь нь тус хотод өрнөдөг гэсэн үг. Тус хотын “Алмаазны дүүрэг”-т байрлах 380 дархны газарт 12,000 гаруй мэргэжлийн дархан ажилладаг бөгөөд боловсруулсан алмаазыг нийт 1500 пүүс, 3500 брокер, дэлгүүрт нийлүүлдэг байна.

“Cut in Antwerp” буюу “Антверпенд боловсруулав” гэх шошготой үнэт эдлэлийг Парис, Сидней, Токио гээд дэлхийн өнцөг булан бүрээс худалдан авах боломжтой. Харин тэдгээр алмааз таны ээмэг, бөгж, зүүлтний шигтгээ болохын тулд Антверпен хотоор хэд хэдэн удаа “дайран өнгөрсөн” нь гарцаагүй. Учир нь, зөвхөн ийм шошготой очир эрдэнэ л хамгийн үнэтэйд тооцогддог аж.

Антверпен хот нь улсынхаа эдийн засгийн төв болдог. Усан боомт, алмааз болон химийн үйлдвэрлэл, худалдаа нь Бельги улсын төсвийн томоохон хэсгийн бүрдүүлнэ. Харин улсын нийт экспортынх нь найман хувийг алмаазны үйлдвэрлэл эзэлдэг бөгөөд жил бүр 39 тэрбум ам.долларын ашиг олдог байна. Тус салбарт 30 мянган иргэн шууд ба шууд бус хэлбэрээр ажилладаг гэсэн тоо гарчээ. Хэдийгээр салбарын тэргүүлэгчид нь еврей үндэстнүүд гэгддэг боловч сүүлийн жилүүдэд Энэтхэг, Армяны худалдаачид хүч түрэн орж ирэх болсон тухай тус хотод байрлах “Дэлхийн алмаазны төв”-өөс мэдэгдсэн байна.

“Ногоон төгөл”

Бельги улс усаар баян. Жилийн 220 өдөр нь хуртай байдаг энэ улсыг “Саарал вант улс” гэж хошигнох нь бий.

Хөх тэнгэрийг ховор үздэг Эрдэнийн энэ хотод ногоон зүйл олон. Антверпен хотыг дагах Шхелдь гол улсынхаа усны нөөцийн ихээхэн хэсгийг бүрдүүлдэг ч байгалийн хишгийг дэмий урсгахгүйн тулд тус улсын Засгийн газар цөөнгүй санал, санаачилгыг хэрэгжүүлж байна. Хэрэглээний усыг боломжит хувилбараар орлуулахын тулд борооны ус хуримтлуулах, саарал усыг цэвэршүүлэн хөдөө, аж ахуй болон ахуйн хэрэглээнд ашиглах төслүүд үр дүнгээ өгч эхэлжээ. Бельги улсыг Фламанд, Франц гэсэн хоёр бүсэд хуваадаг. Фламанд бүсийн Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ногоон дээвэр” төсөлд оролцож байгаа Антверпен, хотын газар нутагт барих бүх шинэ барилгын дээвэр дээр борооны ус хуримтлуулагч суурилуулах шаардлагыг тавьж байгаа аж. Ингэснээр жилд орох 78 000 литр борооны усны 56 160 литрийг хуримтлуулах боломж бүрдэх юм. Үүний дийлэнх хувийг хотын саарал ус хуримтлуулах үйлдвэрт байршуулах юм байна.

Эрдэнийн хот ийнхүү ногоон чиглэлээр ихэд ажил хийсээр байна. ■

ХУВИАРАА ГАДАГШАА СУРГУУЛЬ ХӨӨЦӨЛДӨХ НЬ ЦАГ, МӨНГӨ ДЭМИЙ ҮРДЭГ



Зуны дэлгэр цаг оюутнуудын хувьд алдаж болохгүй алтан боломж байдаг. Гадагшаа сургууль хайх, гадаад хэл сурахад анхаарах хэрэгтэй болдог. Тиймээс гадаад, дотоодод хаана, ямар сургалтын хөтөлбөр байна вэ гэсэн эрэлд морддог. Оюутан сурагчдын энэхүү их эрэлд тус дөхөм болох үүднээс "Нью Войс" компанийн гүйцэтгэх захирал Д.Ууганбаяртай ярилцлаа.

-"Нью Войс" агентлагийн талаар товч танилцуулахгүй юу?

-Манай байгууллага нь боловсол зуучлалын салбартаа анхдагч туршлагатай хамт олон. Энэ ч утгааараа хүмүүс сайн мэдэх байх аа. "Нью Войс" ХХК нь 2005 онд байгуулагдсан ба боловсролын зөвлөгөө зуучлал, мэдээлэл, сургалт, жуулчлал, гадаад хэлний сургалт оюутан солилцооны чиглэлээр үйл ажиллагаа амжилттай явуулж байна. Өнгөрсөн хугацаанд бид 500 орчим оюутан залууг АНУ, Австрали, Фижи зэрэг улсын их, дээд сургууль, коллеж, хэлний бэлтгэл, мэргэшлийн зэрэг олгох сургалт, урт богино хугацааны сургалтууд , соёлын болон зуны хөтөлбөрүүдийг зохион байгуулсаар ирсэн билээ. Манай агентлаг нь гадаад харилцаагаа үргэлж өргөжүүлэн тэлсээр ирсэн ба олон улсын нэр хүндтэй LANGTON, ICEF, ALPHE, ICEF зэрэг байгууллагуудын албан ёсны эрхтэй, гишүүн байгууллага бөгөөд жил бүр, дэлхийн өнцөг булан бүрт зохиодог сургалт семинар, лекцүүдэд идэвхтэй оролцдог .

-Танай байгууллагыг шинэлэг зуны хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаа гэж сонслоо. Энэ талаараа ярина уу?

-2012-2013 оны хичээлийн жилд гадаадад сурч боловсрохыг хүсч байгаа оюутан сурагчиддаа зориулаад Америк, Австрали улсад 50-100 хувийн тэтгэлэгт хөтөлбөр зарлаж байна. Оюутан сурагчдын зуны амралт эхэлснээр цаашдаа ямар мэргэжилтэй болох, хаана суралцах вэ, зуны амралтаа яаж үр дүнтэй өнгөрүүлэх вэ гэдгээ шийдэх хэрэгтэй болдог. Үүнтэй холбогдуулан манай байгууллагын зүгээс зуны амралтаа үр дүнтэй өнгөрүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг зарлаад байна. Эдгээрт Австралийн зуны сургалт, Фижи улсын сургалт, Сингапурт суралцах боломжтой.

-Гадаадад сурахын давуу тал юу вэ?

-Монгол Улс хөгжиж буй орон. Өндөр мэдлэгтэй боловсон хүчин өнөөгийн нийгэмд хэрэгтэй байна. Өндөр мэргэжилтэй боловсон хүчин гэдэг маань зөвхөн номын дуу сонссон төдий биш, хөрвөх чадвартай байх ёстой. Зөвхөн Монголдоо сураад сайн боловсон хүчин болсон хүмүүс байдаг л даа. Тухайн өндөр хөгжилтэй орны соёл, эдийн засгийн орчинд нь сурсан хүн илүү сэтгэж байгууллагын хөгжилд бодитой өөрчлөлт хийж чадаж байгаа юм.

-Танай АНУ, Австралид суралцах тэтгэлэгт хэрхэн хамрагдах боломжтой вэ?

-Тэтгэлэгт 18-аас дээш насны бүх хүн хамрагдах боломжтой. Манай тэтгэлэгт TOEFL, IELTS-ийн шалгалт өгсөн хүмүүс хамрагдана. Түүнчлэн бакалавр болон магистраар сурахыг хүсэж буй хүмүүст сургалтын төлбөрийн 50-70 хувийн хөнгөлөлт үзүүлнэ. Тоо бодъё л доо. Та жилийн 18000 ам.долларын төлбөртэй сургуульд манай дөрвөн жилийн бакалаврын сургалтын хөтөлбөрт хамрагдлаа гэж бодоход жилд 9000- 12600 ам.доллар хэмнэн суралцана гэсэн үг. Ингээд дөрвөн жилийн турш тэтгэлэг авах тул дээрх хугацаанд 36000-49400 ам.доллар хэмнэх боломжтой.

-Хүмүүс гадаад суралцахыг хүсвэл хувиараа хөөцөлдөөд явж болдог. Танай агентлагаар зуучлуулахын давуу тал юу вэ?

-Манайд маш олон хүн ирж зөвлөгөө авдаг. Тэдгээрийн ихэнх нь хувиараа хөөцөлдөж визэнд орж тодорхой хэмжээний мөнгө болон цаг заваа дэмий гарзадсан байдаг. Агентлагаар дамжуулан гадаадад суралцах нь олон давуу талтай. Нэгдүгээрт, оюутнууд хувиараа хөөцөлдсөнөөрөө цаг заваа дэмий үрэх нь бий. Хоёрдугаарт, хэрэггүй зүйлд мөнгө зарцуулж гаднаас мэдэх мэдэхгүй олон төрлийн мэдээлэл авч будилдаг.

-Танайхаар зуучлуулаад явлаа гэхэд очсон хойноо мэдэхгүй чадахгүй асуудалтай бишгүй тулгарна. Энэ тал дээр ямар туслалцаа дэмжлэг үзүүлдэг вэ ?

-Манай байгууллага нь зуучлуулж явсан оюутнуудаа төгсөн төгстөл нь анхаарч, дараагийн шатны сургуулиудад нь зуучилж, шаардлагатай бол эцэг эхчүүдтэй нь ч уулзаж ярилцдаг. Сургуулийн зүгээс жилд 2-3 удаа эргэж очиж, санал бодлыг нь сонсож, тулгамдаад байгаа асуудлуудыг нь шийдвэрлэж өгдөг.

-Гадаадад сурах хүсэлтэй залуучуудад хандан ямар зөвлөгөө өгөх вэ?

-Хүссэн боловсролоо Та эзэмш. Харин бид таны хүсэж буй боловсрол болоод амьдралд чинь өөрчлөлт шинэчлэлийг холбох гүүр болно. ■

ШИЛДЭГ ХЭЛЦЭЛ

“ХҮННҮ КОАЛ” БА МОНГОЛ МЕНЕЖМЕНТ

Монгол залуус юу хийж чаддагийг уул уурхайн салбарт үзүүлж, Монголын уул уурхай, нүүрсний салбарын тэргүүлэгч, үлгэр дууриал үзүүлэгч компани болох нь тэдний эрхэм зорилго. Ийм зорилго, хүсэл өвөртөлсөн ажилтнуудын дундаж нас 30-35. Олон жилийн туршлага гэхээсээ илүү сурч, хийж бүтээх чин эрмэлзлэлтэй залуусын эрч хүч “Хүннү коал”-ыг богино хугацаанд өнөөдрийн амжилтад хүргэжээ.

Д.БАЯР

Хүннүчүүд дахин хүчирхэгжиж эхэллээ гэвэл Та гайхах биз ээ. Эртний Монголын нэгэн хүчирхэг улс Хүннү гүрэн МЭӨ 209-МЭ 93 онд оршин тогтнож байжээ. Модун Шаньюу хаан Монголын анхны төрт улсыг байгуулан удирдан залж, тухайн он цагтаа хамгийн хүчтэй, бусдыг байлдан дагуулж явсан түүхтэй. Ийм л дээдсийнхээ нэрээр овоглосон өнөөгийн Монголын залуус “Хүннү коал” компанийг байгуулан эх орондоо төдийгүй дэлхийд нэрээ дуурсгах болов. Монголын урлаг соёлынхон эртний түүхээ дурсан Хүннү гүрний, Модун Шаньюу хааны тухай өгүүлсэн дэлхийд алдартай “Атилла” дуурийг эх орныхоо алтан тайзан дээр амилуулахад “Хүннү коал” санхүүгийн ивээн тэтгэгчээр ажиллажээ.



Шилдэг IPO

“Asia mining awards”-аас Азийн уул уурхайн шилдгүүдийг зургаан номинациар шалгаруулснаас тавыг нь Монголын болон Монголд үйл ажиллагаа явуулдаг компаниуд хүртсэн юм. Хонконгд болсон “Mines and Money-2012” уулзалтын үеэр дээрх шагналыг гардуулсан билээ. Эдгээрээс манай улсын хувьд хамгийн өвөрмөц нь Оны шилдэг гэрээ хэлцэл номинаци байсан бөгөөд “Хүннү коал” компани энэ шагналыг гардсан юм. IPO хийснээс хойш 18 сарын дотор нэгж хувьцааныхаа үнийг ес дахин өсгөж зарсан явдал нь тус компанийг шилдэг хэлцлийн эзнээр тодруулахад хүргэжээ. Өөрөөр хэлбэл, “Хүннү коал”-ын 20 цент байсан нэгж хувьцааны ханш 1,8 ам.доллараар зарагдсан нь том амжилт байлаа. Жил гаруй хугацаанд ийм амжилтад хүрсэн тохиолдол дэлхийн түүхэнд ховорт тооцогддог ажээ.

Амжилтын нууц юунд байна вэ?

Тус компани гурван жилийн өмнөөс уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй. Австралийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хүннү коал” анхныхаа IPO-г 2010 оны хоёрдугаар сарын 9-нд Австралийн хөрөнгийн бирж дээр гаргаж, олон улсын зах зээлээс хөрөнгө босгох ажлаа эхэлсэн билээ. Хамгийн гайхалтай нь хүннүчүүд хувьцаа гаргасан эхний өдрөө л 20 сая ам.долларыг тус биржээс босгосон юм. Энэхүү хөрөнгө нь компанийн хайгуулыг эрчимжүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлэхэд чиглэж, өнөөдрийн амжилтыг бататгах суурь үндэс болж өгчээ. Тиймээс “Хүннү”-гийн хувьцаа тэр жилдээ Австралийн хөрөнгийн биржийн шилдэг IPO-гоор шалгарч байв.

“Олон улсын зах зээлээс хөрөнгө босгох нь нэлээд өндөр түвшний стандарт шаарддаг. Хөрөнгө оруулагчдын итгэлийг олох нь хамгаас чухал. Гэхдээ хөрөнгө оруулагчид ямар төсөл вэ гэхээсээ илүүтэй ямар баг



Бид чадна, бид бүтээнэ

удирдаж хэрэгжүүлэх юм гэдгийг түлхүү сонирхдог юм билээ. Манай төслийн хувьд эх орондоо, монгол захиралтай, монгол менежментийн баг, гол хувьцаа эзэмшигч нь монгол хүн гэдгээрээ давуу талтай байсан. Мөн австрали түнш маань Австралийн хөрөнгийн бирж дээр олон төслийн хөрөнгө босгож байсан, тэдгээр нь одоо амжилттай явж байгаа нь бас нөлөөлсөн гэж "Хүннү коал" компанийн гүйцэтгэх захирал Т.Лхагвадорж ярьсан.

Мөнгө босгох нэг хэрэг. Мөнгөө итгээд өгсөн хөрөнгө оруулагчдад ажлаа тайлагнах, асуудлаа танилцуулах нь хүннүчүүдэд хамгийн чухал байжээ. Тиймээс тэд сар, улирал бүр тайлан гаргаж, хөндлөнгийн аудитыг ажиллуулж, өөрсдөө биечлэн очиж хөрөнгө оруулагч нартайгаа уулзаж ярьж байсан нь монгол багт итгэх итгэл гэдэг дөрвөн үгийг нэлээд өндөрт өргөсөн аж. "Анхныхаа хувьцааг Австралийн биржид гаргах бэлтгэлийг хангах нь тийм ч амар ажил байгаагүй. Биднээс мэдлэг, ур чадвар шаардсан, бас туршлага болсон гэж компанийн Геологи, уул уурхайн ерөнхий менежер Д.Чинбат хэлсэн юм.

"Хүннү коал" өнөөдөр Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говь-Алтай зэрэг аймагт 14 хайгуулын лицензтэй бүхий төсөл хэрэгжүүлж байна. Анхных нь төсөл болох Өмнөговь аймгийн Баян-Овоо сум дахь Цант-Уулын уурхай нь саяхнаас ажиллаж эхлээд байна.

Банпу ба Хүннү коал

Тайландын нүүрсний магнат гэгддэг "Банпу" компани Монголын уул уурхайн салбарт өнгөрсөн оноос орж ирсэн. 2011 оны гуравдугаар сард "Хүннү коал"-ын хувьцааны 12,4 хувийг 45 сая ам.долларааар худалдан авснаар "Банпу" Монгол Улстай холбогдож, улмаар багагүй хугацааны дараа хувьцааны нийт багцыг 447 сая ам.долларааар авах санал тавьж, "Хүннү коал"-ын албан ёсны хөрөнгө оруулагчаар тодорсон юм.

Европын хямрал үргэлжилсэн, уул уурхайн компаниудын хувьцааны ханш унаж, зах зээл яаж ч магадгүй тийм эрсдэлтэй байдал үүссэн байсан, өнгөрсөн жил. Ийм үед манай захирлуудын зөвлөл хуралдаж "Банпу"-гийн саналыг зөвшөөрөхөөр шийдсэн. Учир нь "Банпу" санхүү болоод нүүрсний салбарт олон жилийн туршлагатай компани. Хамгийн гол нь манай менежментийн багийг өөрчлөхгүй. Та бүгдийн хийж буй ажил сайн байна. Монгол хүн нутагтаа эзэн нь байж ажлаа хийх ёстой гэсэн байр суурь нь их чухал байсан гэж Т.Лхагвадорж захирал сонирхуулсан.

"Банпу" нь Австралийн "Centennial coal" компанийг хоёр жилийн өмнө хоёр тэрбум ам.долларааар худалдаж аваад нэг ч хүн өөрчлөөгүй үйл ажиллагаа явуулж буй ажээ. "Хүннү коал"-ын удирдлагууд өнөөдөр сар бүр хөрөнгө оруулагчтайгаа уулзаж тайлан, үйл ажиллагааныхаа талаар ярилцдаг байна. "Банпу"-гийн талаас төслүүд төрийн бодлого, дүрэм журамтай хэрхэн уялдаж байна, тухайн асуудлыг шийдвэрлэх ямар гарц байна, Монголын нүүрсний салбарт том тоглогч болохын тулд ямар арга хэмжээ авмаар байна зэрэг алсыг харсан, том асуудал ярьж, санаа оноо, туршлагаасаа хуваалцдаг гэсэн.

"Банпу" нь Тайландын төдийгүй дэлхийн хамгийн том нүүрсний компаниудын нэг. Зах зээлийн үнэлгээ нь зургаан тэрбум ам.доллар. Индонез, Хятад, Австрали зэрэг оронд үйл ажиллагаа явуулдаг. Жилдээ 40 сая тонн нүүрс олборлодог, мөн хэд хэдэн оронд цахилгаан станц барьжээ. Компанийн голлох хувьцааг Тайландын хоёр гэр бүл эзэмшдэг. Бусад хувьцаа нь олон улсын хөрөнгийн бирж дээр арилжигддаг хувьцаат компани аж.

Монгол менежмент

Энэ үг "Хүннү коал"-ын хувьд их эрхэмсэг. Хэдийгээр гаднын хөрөнгө оруулалттай ч монгол менежментээр ажиллах нь тус компанийн байгуулагдах цагаасаа баримталсан гол зарчим. Өөрөөр хэлбэл, монгол залуус юу хийж чаддагийг уул уурхайн салбарт үзүүлж, Монголын уул уурхай, нүүрсний салбарын тэргүүлэгч, үлгэр дууриал үзүүлэгч компани болох нь тэдний эрхэм зорилго. Ийм зорилго, хүсэл өөртөлсөн ажилтнуудын дундаж нас 30-35. Олон жилийн туршлага гэхээсээ илүү сурч, хийж бүтээх чин эрмэлзлэлттэй залуусын эрч хүч "Хүннү коал"-ыг богино хугацаанд өнөөдрийн амжилтад



хүргэжээ. Анхлан 10-уулаа “Макс тауэр”-ийн оффист ажлаа эхэлж байсан хүннүчүүд одоо 200 гаруй ажилтантайгаар “Сентрал тауэр-ын байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани Монголын хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж, монгол компаниудаа дэмжиж ажилладгаа нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байна гэж үздэг. Мөн цалингийн бодлогоор ажилтнуудынхаа нийгмийн хангамжийг сайжруулж, тэднийг амар тайван ажиллаж амьдрах нөхцөлийг бүрүүлэхийг хичээдэг ажээ. Тус компанид гадаад, дотоодод сургууль төгссөн олон залуу ажилладаг. Тэдэнд тодорхой эрх мэдэл өгч, хариуцлага үүрүүлж, итгэл хүлээлгэж ажиллах нь “Хүннү коал”-ын амжилтын нэг нууц гэж хэлж болох. Ямар ч залуу хүн өөрийнхөө хүчээр юм хийж бүтээхийг хүснэ. Түүндээ ч сэтгэл хангалуун ажиллаж амьдарна. Чи энэ төслийг гардаж хариуцаад босгоод ирээ гэхэд тэд бүх хүчээ шавхан өөртөө итгэлтэйгээр өөриймсөг ажилладаг талаар компанийн удирдлагууд нь ярих дуртай.

Австрали, Тайланд гээд гаднын орны мэргэжилтнүүдтэй харилцаж хамтран ажиллаж байгаа нь хүннүчүүдэд маш их туршлага болж, мэдлэг хуримтлуулж буй нь тодорхой. “Бидний хувьд уул уурхайн томоохон төсөл дээр ажиллаж, алдаж оносон туршлагагүй. Харин манай залуусын мэдлэг боловсрол, харилцаа, хэлний соёл, сэтгэхүй, хандлагыг гаднынхан ихэд үнэлдэг. “Банпу”-гийн удирдлагууд манайх танай залуусаас сурах зүйл их байна гэж хэлсэн” хэмээн Т.Лхагвадорж захирал ажилтнуудаараа бахархсан юм.

Цант-Уул ба нүүр царай

“Хүннү коал”-ын хувьд анхны нүүр царай болсон төсөл нь Цант-Уул. 2010 оны долдугаар сараас хайгуул хийж эхэлсэн тус төсөл жил гаруйхны хугацаанд ашиглалтын лиценз авч, уурхай болоод байгаа. /Төслийн он цагийн хэлхээсийг хүснэгтэд харуулав/ Энэ процесс нь өөрөө маш том амжилт бөгөөд шилдэг хэлцэл шагнал авах гол хөшүүрэг нь болжээ.

Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг Цант-Уулын уурхай нь нийтдээ 69233 га талбайг хамарч, Улаанбаатар хотоос 610, Даланзадгадаас 160, Баян-Овоо сумаас 40, урд хилээс 210, Тавантолгойн уурхайгаас өмнө зүгт 70 км-ийн зайд оршдог. Эрчим хүчний нүүрсний хэмжээ нь Жорк стандартаар 167 сая тонн. Нарийвчилсан хайгуулаар нөөцийн хэмжээ нэмэгдэх төлөвтэй байгаа тухай Д.Чинбат ярилаа. 110 ажилтантай тус уурхай боловсон хүчний бодлогоо 2-3 жилийн өмнөөс хэрэгжүүлж, техникийн ур чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэжээ. Мөн уул уурхайн салбарын боловсон хүчин дутагдалтай байгаа үед ШУТИС-д 20 гаруй оюутныг цалинтай сургаж байгаа гэнэ. Хөрөнгө мөнгө босгож, техник технологийг худалдан авч болно. Харин уул уурхайн салбарт боловсон хүчний асуудал хамгийн хүнд болж буйг “Хүннү коал”-ын удирдлагууд мэдэрч байгаа гэсэн.

Хүннүчүүд Баян-Овоо сум, орон нутгийнхантай нэлээд ойр дотно ажилладаг. Сумыг хөгжүүлэх бодлоготой компанийнхаа төлөвлөгөөг уялдуулж хамтарч ажиллахыг чухалчилдаг. Хайгуулын түвшинд тодорхой хэмжээгээр сумыг дэмжиж ирсэн бол уурхай болж өргөжсөнтэй холбогдон өргөн хүрээнд хамтарч ажиллах алсыг харсан төлөвлөгөө боловсруулсан байгаа гэнэ. Тухайлбал, Засгийн газраас хэрэгжүүлж буй шинэ сумын төв төсөл дээр хамтарч ажиллажээ. Сумын төвд 60 айлын уурхайчдын хотхон барих юм байна.

Баян-Овоо сумын эргэн тойронд уурхай байгуулагдаж ажиллах насны залуус нутгаасаа олноор нүүснээр сумын төвд хүүхэд, хөгшид л үлдэж бараг л эзгүйрсэн ажээ. Тиймээс иргэдийг орон нутагтаа эргэн ирж ажиллаж, амьдрах боломж нөхцөлөөр хангах, өөрөөр хэлбэл нутгийн хөгжлийг дэмжих бодлого барих шаардлагатай буй аж. Онгоцоор нисэж очиж ажиллахаас илүүтэй тухайн



Цант-Уулын уурхай

сум орон нутагт гэр бүлээрээ тогтвортой ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэх ач холбогдолтой гэж тэд үзэж байгаа юм.

Харин уурхайн хөгжлийн хувьд нүүрс гаргахаасаа өмнө замын асуудлыг шийдэх үүднээс уурхайгаас Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн автозам хүртэлх 40-өөд км-ийн барилгын ажлыг эхлүүлжээ.

Төрөөс уул уурхайн дэд бүтцийг хөгжүүлэхэд дорвитой алхам хийх талаар сүүлийн үед нэлээд ярих болсон. Үүнтэй Лхагвадорж захирал санал нэгдэж байна. Тэдний компанийн хувьд ч дэд бүтцийг шийдэхэд багагүй хөрөнгө зарцуулж байгаа гэнэ. “Төр уул уурхайн салбарыг бэлэн мөнгөөр хараад байна. Татвараас гадна бид ханган нийлүүлэлтийн олон компани, иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх бизнес нь болж ажилладгийг бодолцох хэрэгтэй шүү дээ. Уул уурхайн компаниудыг хөл дээрээ боссоны дараа ашиг авах талаар ярих нь зүйтэй. Гэтэл өлгийнөөсөө гарч амжаагүй байхад нь татвар, ашгийн тухай сануулах нь тийм ч зохистой бодлого биш болов уу хэмээн тэрбээр ярьсан юм.

Цант-Уул уурхайн он цагийн хэлхээс

2010.07.15. Хайгуулын ажил эхэлсэн

2011.04.06. ЭБМЗ-өөр нөөцөө батлуулсан

2011.07.05. MV-016872 тоот Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл авсан

2011.08.29. ТЭЗҮ батлагдсан

2011.11.01. Уулын бэлтгэл ажил эхэлсэн

2011.12.24. Цант-уулын уурхайгаас Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн зам хүртэлх 36,8 км урттай хайрган хучилттай түр замыг комисст хүлээлгэн өгсөн.

2012.03.15 Уурхай хүлээж авах Улсын Комисс ажиллаж холбогдох бичиг баримт, уурхайн бэлтгэл ажилтай танилцсанаар 2012.04.01-ний өдрөөс үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэхээр зөвшөөрөл олгосон. ■



“Хүннү коал” эко баазыг таван га газарт байгуулжээ.

ОЮУТОЛГОЙН БУЛАН

2013

Австралийн хэрэглээний эдийн засгийн зөвлөх компани “Би Эй Экономикс” судалгаанд манай улсын эдийн засгийн өсөлтийг 2010-2030 оны хооронд 7.1 хувь, 2031-2043 онд 5.4 хувь хэмээн таамаглажээ.



Азийн хөгжлийн банк /АХБ/-ны “Азийн хөгжлийн төлөв-2012” тайланд Монголын эдийн засаг ирэх 2013 онд 17.5 хувьд хүрнэ” хэмээн тооцжээ. Энэхүү эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлийн үр өгөөж нөлөөлнө гэж тэд үзсэн байна. “Азийн хөгжлийн төлөв” тайлан нь Азийн хөгжиж буй улсуудын макро эдийн засгийн багц судалгааг бүс нутагт болон улс орны байдлаар гаргадаг эдийн засгийн судалгааны гол баримт бичгийн нэг. Тус тайланд Монгол Улс одоогийн өндөр өсөлтөө урт хугацаанд хадгалахын тулд эдийн засгаа төрөлжүүлэх шаардлагатай хэмээн зөвлөжээ.

Ойрын жилүүдэд дэлхийн эдийн засагт хамгийн өндөр өсөлттэй, цөөн улсын нэгэнд нь манай улс толгой цохиж явна. Толгой цохих шалтгаан нь өнөөдрийн Оюутолгой ба түүнийг тойрсон орд газар, орд газруудад цутгаж буй хөрөнгө оруулалтын үр шим гэвэл хол зөрөхгүй л болов уу. Энэ онд манай улсын эдийн засаг 15 хувийн өсөлттэй байна гэж АХБ-ны эдийн засагч Л.Амар хэллээ. Монголын эдийн засгийн өнгийг тодорхойлж буй “Оюу Толгой” төсөл ердөө л 4-5 жилийн дотор дэлхийн эхний гуравт багтах уурхай болохоо саяхан мэдэгдсэн. Энэхүү мэдэгдэлтэй хамт Монголын эдийн засаг хэтийн хугацаандаа томрох нь гэсэн хүлээлт олон улсад бий болж байна.


Өнөөдөр улсын төсвийн орлогын дийлэнх хувийг уул уурхайн салбарынхан бүрдүүлж байна. Энэ оны гуравдугаар сарын байдлаар экспортын 98 хувийг зөвхөн уул уурхайн бүтээгдэхүүн дангаар эзэлжээ. Эдийн засгийн өсөлтөө дагаад улсын төсвийн орлого, зарлага ч огцом тэлэв. Тиймээс уул уурхайн хөрөнгө оруулалт улс орны хөгжилтэй эмээлийн бүүрэг шиг хоёр тийшээ бус оонын эвэр шиг ижилсэж явах ийм цаг үетэй нүүр тулж байна. 2020 он гэхэд дэлхийд боловсруулах зэсийн нийт эрэлт хэрэгцээ 27 сая тонн хүртэл өсөх хандлагатайг “Оюу Толгой” компанийн гүйцэтгэх захирал Камерон Макрей “Metals Mongolia-2011” чуулганы үеэр онцолж байв. Тэрбээр өмнийн говиос дэлхийн зэсийн зах зээлийн тодорхой хувь хамаарч, “Оюу Толгой” олон улсад гуравт жагсах уурхай болохыг нүүр бардам тунхаглалаа. Манай гараг илэрсэн зэсийн нийт нөөцийн 14 хувь нь Азид бий. Үүний хоёр хувь нь Монголд ногддог. Тэгвэл, 2013 онд Монголд юу болох вэ?

1.


Сонгууль болдгоороо л болж, шинэ Засгийн газар багаа бүрдүүлнэ. Монголын мянга мянган маргааш эхэлнэ. Улс төрийн сонгууль бол эдийн засагт тийм ч таатай нөлөөлөх хүчин зүйл биш юм. Харин ирэх онд Монголын эдийн засагт шинэ хуудас, шинэ боломжит зах зээлийн үүд хаалга нээгдэх гэж байна.

Учир нь, “Оюу Толгой” төслийн баяжуулах үйлдвэр энэ оны наймдугаар сард ашиглалтад орж, анхны бүтээгдэхүүн 2013 онд гадаад зах зээлийг зорино. Дуулиан, шуугиантай хөрөнгө оруулалтын гэрээг баталгаажуулсан Монголын “Оюу Толгой” олборлолтоо ийн эхлүүлэх юм. Энэ нь “Оюу Толгой” төсөл анхны хөрөнгө оруулалтаа 4.5-7 жилийн хугацаанд нөхнө гэсэн үйл ажиллагааны зорилтыг бүр ч тодорхой болгож байгааг тус компанийнхан тэмдэглэв.

“Оюутолгой” ордод буй зэсийн хүдэр нь ойролцоогоор зургаан хувийн агууламжтай учраас дэлхийн хамгийн цэвэр зэсийн агууламжтай ордод зүй ёсоор багтаж байна.







Эх сурвалж: "Би ЭйЭкономикс" судалгааны компани

Өөрөөр хэлбэл, зэсийн агууламж өндөр, үйлдвэрлэлийн ажил эрчимтэй өрнөж байвал удахгүй бид нэмүү өртөг шингэсэн, баялгийн ашгийг хүртэх боломжтой болно гэсэн үг. Дэлхийн хамгийн том зэсийн хэрэглэгч Хятадын зах зээл алгаа тосон хүлээж байна. Тиймээс аль болох нэмүү өртөг шингээж, гүн боловсруулах нь мэдээж Монголд ашигтай. "Бүрэн хэмжээгээрээ "Оюу Толгой" төсөл үйл ажиллагаа явуулж, манай улсын ДНБ-ий 30 гаруй хувийг үйлдвэрлэх юм бол эдийн засгийн өсөлтийг хурдасгана" хэмээн Эдийн засагч Л.Оюун хэллээ. Тэгвэл "Эдийн засгийн өндөр өсөлтийг хөгжил болгоё" гэж эдийн засагч Д.Жаргалсайхан нийтлэлдээ онцолсон. "2020 он гэхэд манай улсын эдийн засаг "Оюу Толгой" төслийг хэрэгжүүлснээр 35 хувиар өсөх хандлагатай" хэмээн "Оюу Толгой зэсийн ордын ашиглалт, Монголын макро эдийн засгийн үр дагаврын үнэлгээ" судалгааны бүтээлд тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл, 2020 он гэхэд эдийн засгийн багагүй хувь "Оюу Толгой" төслөөс шууд хамааралтай болно гэсэн үг.

Хөрөнгө оруулалтын гэрээнд тусгаснаар "Оюу Толгой" зэс алтны уурхай 2017 онд бүрэн хүчин чадлаараа ажиллаж, 450 мянган тонн зэс болон ихээхэн хэмжээний алт зэрэг бусад дайвар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх учиртай. Үйлдвэрлэлийн хэмжээг дагаж, гадаад худалдааны бараа эргэлт ч нэмэгдэнэ. Сүүлийн нэг жилийн дотор л гэхэд манай улсын гадаад худалдааны эргэлт 85 хувиар өссөн байна. Уурхай хамгийн багадаа 59 жил үйл ажиллагаа явуулах учраас өмнийн говийн дэд бүтцийн асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэйг учир мэдэх улс тайлбарлаж байна. Байгаль орчинд ээлтэй, бага зардлаар ихийг тээвэрлэж болох төмөр зам барих ажлаа Засгийн газар яаралтай шуурхайлахгүй бол алдагдалд орж мэдэх нь. Дэлхийн зах зээл Монголыг хүлээхгүй шүү дээ.

2.

"Оюу Толгой" компанийн 64 хувийг эзэмшигч "Айванхоу майнз" компанийн Ерөнхий гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Роберт Фрийдлэнд огцорч, түүний албан тушаалд Кей Приестли томилогдлоо. "Оюу Толгой" компани шинэ эзэнтэй болсон ч компанийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж, эрчимжинэ хэмээн Камерон Макрей захирал тайлбарласан юм. Тэрбээр "Рио Тинто" "Айвенхоу майнз"-ын 57 хувийг эзэмших болсон нь "Оюу Толгой" төслийн эзэмшилд ямар ч өөрчлөлтийг авчрахгүй. Харин ч "Айвенхоу майнз"-ын ТУЗ болон менежментийн бүтцэд өөрчлөлт хийснээрээ асуудал улам л энгийн болж байгаа" гэлээ.

"Оюу Толгой" төсөлд шаардлагатай санхүүжилтийг хангахад "Рио Тинто" дэмжлэг үзүүлэхээр болж байгаа юм байна. Өнгөрсөн хугацаанд "Рио Тинто"-гоос "Айвенхоу майнз" руу богино хугацаатай завсрын санхүүжилт хийж байсан бол одоо урт хугацаанд тогтвортой санхүүжилт хийх боломж илүү нээлттэй болж байна гэж Камерон Макрей онцлов. Австралийн хэрэглээний эдийн засгийн зөвлөх компани "Би Эй Экономикс" судалгаанд манай улсын эдийн засгийн өсөлтийг 2010-2030 оны хооронд 7.1 хувь, 2031-2043 онд 5.4 хувь хэмээн таамаглажээ.

3.

Олон улсын валютын сангийн тооцоогоор Монгол Улсын Засгийн газар нь Оюу Толгой төслийн үр дүнг голлон хүртэгч байна. Нийт ашгийн 55 хувийг Монгол Улс хүртэнэ гэсэн итгэл найдварын зул бөхөх учиргүй, унтрах ч ёсгүй. Уул уурхайн салбарт гарч буй удирдлагын халаа сэлгээг хамгийн хүндээр хүлээж авах нь монголчууд. Учир нь уул уурхайн орлого баттай гэдэгт эргэлзэх айдас төрж байсан. Гэхдээ энэ зууны гэрээ хэлцэл бол хэзээний баталгаатай, итгэж найдаж болох буух эзэн, буцах хаягтай. Тиймээс хавтгай дэлхийд оршин буй учраас гэрээний зарчмаар л улс орны хөгжил, эдийн засгийн "мотор" ажиллах учиртай. Тоглоомын дүрэм ч ийм. Тиймээс "Оюу Толгой"-г улс төржүүлэх шалтгаан байна уу. "Сонгуульдах" шалтаг байлаа гэхэд хэнд ашигтай вэ. Бүтээн байгуулалтын оргил үед төсөл дээр 15 мянган хүн ажиллах бөгөөд эдгээрийн 10 мянга нь монголчууд байна хэмээн "Оюу Толгой" компани цахим хуудсандаа /www.ot.mn/ тэмдэглэжээ.

4.

Өмнийн говьд сүндэрлэж буй "Оюу Толгой" төслийн барилга, бүтээн байгуулалтын ажил одоогийн байдлаар 80 хувьтай явна. Ажлын гүйцэтгэл 2010 онд баталсан төлөвлөгөөнөөс зургаан сараар түрүүлж яваа юм байна. Тодруулбал, бүтээн байгуулалтын ажлыг 33 сард багтаах төлөвлөгөөтэй байсан хэдий ч өдгөө 27 сард багтаах боломж бүрдсэн гэх таатай мэдээ чих дэлслээ. "Ирэх наймдугаар сар гэхэд баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулна. 2013 оны эхний улиралд багтаан анхны борлуулалтаа хийнэ. Эхний ээлжинд 500 мянган тонн баяжмал үйлдвэрлэх тооцоо бий. Энэ хэмжээгээ ойрын 4-5 жилд дөрөв дахин нэмэгдүүлж хоёр сая тоннд хүргэх зорилготой ажиллаж байна" хэмээн "Оюу Толгой" компанийн гүйцэтгэх захирал онцлов.

Эхний ээлжийн орлогоосоо ногдол ашиг өгнө гэж шахахгүйгээр уурхайн өргөтгөлийн ажлыг санхүүжүүлэх гэнэ. Энэ тохиолдолд "Оюу Толгой" уурхай дэлхийд өндөр хүчин чадалтай, илүү үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ гэж тайлбарлав. Одоогийн байдлаар "Оюу Толгой" анхны бүтээгдэхүүнээ гаргаж авах хүртлээ нийтдээ зургаан тэрбум ам.доллар зарцуулаад байгаа аж. Мөн ойрын дөрвөн жилд 4-5 тэрбум ам.доллар нэмж зарцуулахаар тооцжээ. Энэхүү нэмэлт хөрөнгө оруулалтаар голчлон цахилгаан станц, гүний уурхайн бүтээн байгуулалт, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл гэсэн гурван чиглэлд зарцуулахаар төлөвлөж байгаа аж. Шинэ зах зээлийн хуудас нээх 2013 оны өмнөх бэлтгэл ажил ийм өнгө аястай өрнөсөөр. ■

ҮНЭ ХАНШ

НООЛУУРЫН ҮНЭ ГАЗАРДЖЭЭ

Гадаад зах зээл дээр өнгөрсөн оны дундуур ямааны самнасан ноолуур кг нь 120-130 мянган төгрөгийн үнэтэй байсан бол өдгөө 100 орчим мянган төгрөгт хэлбэлзэж байна. Үүнийг бохир ноолуурын ханш руу шилжүүлж тооцох юм бол энэ жил ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ нь 45-50 мянган төгрөгт хэлбэлзэх тооцоо гарч буй аж.



Б.ЭНХЦЭЦЭГ

Жилийн жилд өгөөж нь түмэн олны нүдэнд үзэгдэж, гарт баригддаг бизнесийг ноолуурын наймаа гэж хэлж болно. Хаана хаанаа хачин сайхан хаялагатай энэ бизнест ханш гэж хатуухан зүйл бий. Тэр ханшийг хэлж таамаглахад хэцүү. Алт, зэс, газрын тосны үнэ адил эмзэг мэдрэмтгий.

Ханш харьцангуй өндөр ч бай, шалан дээр унасан хямдхан ч бай ноолууraa тушаасан малчдын дотор “ирэх жил ямар ханштай байх бол оо” гэсэн бодол зурсхийдэг. Хойтон жилийн наадам хол байна даа гэдэг шиг тэд дараа хавар болтол ноолуурын ханшид чих тавиастай. Тэгвэл энэ жилийн хувьд ноолуурын нэг кг тутмын үнэ өмнөх жилийн хаалтын үнэ болох 48-50 мянган төгрөгтэй дүйх ханштай эхэлсэн талаар Монголын ноос ноолуурын холбооны дэд тэргүүн Г.Ёндонсамбуу хэлсэн. Тэрбээр “Ноолуурын үнэ хүссэн, хүсээгүй 40 мянга руу орж, улмаар 35-36 мянган төгрөгт тогтох хандлагатай байна” гэв.

Өнөөдрийн байдлаар /дөрөвдүгээр сарын 24/ нэг кг ноолуурын үнэ 45 мянган төгрөг болж буужээ. Харин малчдын хувьд ямар чөтгөрийн хорлолд автсан юм бүү мэд, “Ноолуурын үнэ 100 мянган төгрөгт хүрнэ гэнэ лээ” гэсэн цуурхал дэгдэж, нэг хэсэгтээ ажиглалтын байдалд орсон тул дээрх анхны ахиу ханшаар өгч чадсан хүн ховор бололтой. Өөрөөр хэлбэл, “Их санасан газар есөн шөнө хоосон хононо” гэдэгчлэн нэг кг ноолууraa 100 мянган төгрөгөөр өгчихвөл ч баяжих юм байна даа гэсэн бодол тээн, баясан суусан малчдыг ханшийн огцом уналт сандаргав.


Хэдийгээр энэ нь малчдыг гонсойлгож байгаа ч нөгөө талаар үйлдвэрлэгчдийг гялайлгаж буй аж. Учир юу гэвэл, Монголын ноос ноолуурын холбооноос түрүү жил ноолуурын улирал эхлэх үеэр уг бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн


нээлтийн ханшийг нэг кг тутам нь 56-58 мянган төгрөгт байх болов уу хэмээн таамаглаж байсан ч түүхий ноолуурын эхний ханш 70 мянган төгрөгөөс эхлээд зогсоогүй удаан хадгалагдаж олон түмний нүдийг орой дээр нь гаргасан үйл явдал болсныг хэн хүнгүй санаж байгаа биз ээ. Мэргэжлийн холбооноос дэвшүүлсэн таамгийг будилуулсан хэргийн эзэд нь Монголын ноос ноолуурын зах зээлд сүүлийн арав гаруй жил дураараа дургисан хятадууд юм. Дэлхийн ноолуурын зах зээлд цахиур хагалах магадлалтай Монгол Улсын гол өрсөлдөгч бол урд хөрш. Тиймээс хятад ноолуурын наймаачид Монголын өргөн уудам нутгийн аль хэсгээр нутагладаг малчдын ямааны ноолуур эрт гардаг, аль нь чанартай байдгийг анддаггүй. Тэд өнгөрсөн жил урд урд жилүүдээс өндөр үнэ хэлж, манай ноолуурыг хуй хамах бизнесийн арга хэрэглэсэн хэрэг. Нэг үгээр хэлбэл, Монголын ноолуурын салбарт Хятадын ноёрхлыг бүрмөсөн тогтоох гэсэн бодлоготой байсан ч бүтэлгүйтсэн тухай Ёндонсамбуу хэлсэн.

Харин энэ жилийн хувьд манай ноолуурын зах зээлд тийм ч хүчтэй өрсөлдөөн явагдахгүй нь бололтой. Учир нь, дэлхийн ноолууран бүтээгдэхүүний худалдаанд голлох нөлөөтэй Европын зарим орны эдийн засаг нэлээд хүнд байгаа. Түүнчлэн ноолуурын ханш дэлхийн зах зээл дээр 4-5 жилийн давтамжтай өгсөж, уруудах циклтой байдаг аж. Тиймээс сүүлийн жилүүдэд харьцангуй өндөр ханштай байсан ноолуурын үнэ энэ жилээс уруудаг үе нь эхэлсэн гэж ойлгож болох нь ээ. Гадаад зах зээл дээр өнгөрсөн оны дундуур ямааны самнасан ноолуур кг нь 120-130 мянган төгрөгийн үнэтэй байсан бол өдгөө 100 орчим мянган төгрөгт хэлбэлзэж байна. Үүнийг бохир ноолуурын ханш руу шилжүүлж тооцох юм бол энэ жил ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ нь 45-50 мянган төгрөгт хэлбэлзэх тооцоо гарч буй аж. Үүнээс гадна ноолуурын салбарт манай улсын гол өрсөлдөгч Хятад улсын төр засгаас ноолуурын арилжаа наймаа эрхлэгч, үйлдвэрлэгчдээ хүүтэй, хүүгүй их мөнгөөр дэмждэгээ зогсоожээ.

Ийм шалтгаануудын улмаас манай ноолуурын чиглэлийн үндэсний үйлдвэрүүд дотоодын зах зээлээс түүхий эдээ тааваараа цуглуулах боломж бараг анх удаа бүрдэж байна гэж хэлж болох юм.

Хятадууд өмнөхийн адил ноолуур авахаар их мөнгө өвөртлөөд, олноор орж ирсэн ч дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд өрсөлдөх чадвар харьцангуй сайтай байгаа юм. Ноолуурын үндэсний үйлдвэрүүдийн хувьд ихэнх нь өнгөрсөн онд Засгийн газрын ноос ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих болон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бонд авсан учраас өмнөх жилүүдийг бодвол хөрөнгөлөг байгаа гэсэн үг. Тиймээс үйлдвэрлэгчдийн хувьд хэдийгээр хятадуудтай үнийн дайн хийхгүй ч гэсэн чанартай ноолуурыг малчны





Эх сурвалж: Монголын ноос ноолуурын холбоо

хотноос харьцангуй өндөр үнээр авах боломжтой гэдгээ сонин хэвлэлээр мэдэгдсэн билээ.

“Эмээлт” түүхий эдийн захын ноолуурын наймаа эрхлэгчдийн хэлж байгаагаар сүүлийн үед хүйтэн салхи тавьж, цас орж байгаа нь ноолуурын чанарт муугаар нөлөөлж байгаа аж. Ноолуурын түүхий эд бэлтгэл нутгийн зүүнээсээ баруун тийшээ чиглэжээ. Энэ нь ч хавар болгон ноолуур харьцангүй өндөр ханштайгаар зүүн гурван аймгаас эхлээд, Хөвсгөл дараагаар нь баруун аймгууд руу жолоогоо залж үнээ доошлуулсаар хаалтаа хийдэг тогтсон жишиг билээ.

Мөн Хөдөө аж ахуйн биржийн тухай хууль ирэх зургаадугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэхтэй холбоотой ноос ноолуурын дотоодын зах зээлд хэрхэн өөрчлөлт орох талаар үйлдвэрлэгчдээс сонирхлоо.

“Ээрмэл” ХХК-ийн дэд захирал А.Төмөр-Очир “Бирж бий болж, сум бүрд хоршоо байгуулахын тулд нэлээд хугацаа хэрэгтэй” гэсэн бол Г.Ёндонсамбуу “Бэлтгэл ажил их учраас ноолуурын салбарын хувьд шууд хэрэгжиж эхлэхэд хэцүү. Энэ жил арай чадахгүй. Хойтонгоос ноолуурыг биржээр худалдаалж эхлэх байх” гэв.

Түүнчлэн Биржийн тухай хуультай холбоотой ноос ноолуурын ченжүүд нэгдэж, Монголын ноос ноолуур бэлтгэн нийлүүлэгчдийн холбоо гэж байгуулсан нь шинэ үзэгдэл гэж хэлж болох юм. Түүнчлэн манай ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд япончууд “Нэг далбаан дор нэгдэж Европ руу гар. Тэгвэл амжилт олно” гэж зөвлөсөн учраас “Монголын тансаг үс” гэсэн нэрийн дор дэлхийн зах зээл дээр гардаг болохоор санал нэгдэж, бэлтгэл ажилдаа шамдан орсныг дуулгахад таатай байна.

Нэг үгээр хэлбэл, ноолуурын үйлдвэрийнхэн хятадууд түхий эдийг үнэ цохиж аваад байна гэдэг гоншигнолоосоо салж, зөвхөн дотоодын зах зээлийн ханштай зууралдах биш, малчид, бизнесмэн, ченж гээд тус зах зээл дээр ажилладаг хүн бүр үйлдвэрлэгч гэдэг нэгэн малгайн дор нэгдэж, алсыг харах боломж бололцоо энэ жилээс нээгдэж байх шиг. ■

БРЭНД

“MONGOLIAN NOBLE FIBRE” БРЭНДИЙГ ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛД УДАХГҮЙ ГАРГАНА

Манай төслийн гол зорилго нь гадаадын зах зээлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Ингэхдээ дээд зэргийн өндөр чанарын түүхий эдээр, чанартай, олон улсын хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнийг өндөр үнээр худалдаж, Монголын брэндийг дэлхийн зах зээлд гаргах зорилготой.

Б.УУГАН

“Брэнд” гэсэн үгийг сонсоод танд чанар, нэр хүнд, үнэ цэнэ гэсэн ойлголт шууд бууж байгаа байх. Энгийн жишээ хэлэхэд, бид ойрын хөрш Солонгос улсыг кимчи, Голланд гэвэл бяслаг, Францыг Doir, Chanel, Gucci зэрэг тансаг үнэртэй усаар, Их наран улсыг Sony, Hitachi, Panasonic брэндийн цахилгаан бараагаар, Грекийг чидун жимсээр, Америкийг хазсан алимны дүрс бүхий I Phone, I Pad, I Pod, зөөврийн компьютергүйгээр төсөөлөхгүй байхын аргагүй. Нэг ёсондоо тухайн улсынхаа нэрийг дэлхийн тавцанд таниулж, нэрийн хуудас нь болж яваа брэнд юм.

Тэгвэл Монгол Улс үүнтэй адил дэлхийн тавцанд хөдөө, аж ахуйн салбарын бүтээгдэхүүнээ брэнд болгох гарцыг эрчимтэй эрэлхийлж байна. Энэ хүрээнд Азийн хөгжлийн банкны Хөдөө аж, ахуйн маркетинг, брэндийг хөгжүүлэх төслийг өнгөрсөн оноос санаачлан, хэрэгжүүлж байгаа юм. Ялангуяа монгол ноос, ноолуурыг хамтын маркетинг брэндтэй болгож, “Mongolian noble fibre” гэдэг нэрээр дэлхийн зах зээлд гаргахаар зорьж буй аж.

Тус төслийн захирал Юрген Мендритцки болон төслийн дэд дарга Монгол талын захирал Б.Эрдэнэбилэг нартай ярилцлаа. Юрген Мендритцки нь 30-аад жил энэ чиглэлээр дагнан Латин Америк, Өмнөд, Зүүн болон Төв Азийн орнуудад ажиллаж байсан туршлагатай нэгэн аж.

-Яагаад заавал хөдөө, аж ахуйн салбарыг онцолж, маркетинг, брэндийн төсөл хэрэгжүүлэх болсон бэ?

Юрген Мендритцки: Монголын ноолуурыг дэлхийд чанараараа хоёрдугаарт ордог гэдгийг дэлхийд тэр бүр мэдэхгүй. Тиймээс энэ томоохон давуу талаа сурталчилж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломжтой гэж харж байна. Манай төслийн гол зорилго нь гадаадын зах зээлд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх юм. Ингэхдээ дээд зэргийн өндөр чанарын түүхий эдээр, чанартай, олон улсын хэрэглэгчдийн



хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүнийг өндөр үнээр худалдаж, Монголын брэндийг дэлхийн зах зээлд гаргах зорилготой. Үүний хүрээнд хөдөө, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдэд брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд маркетинг, чанарын зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах улмаар бүтээгдэхүүнээ экспортод гаргах боломж олгохоор ажиллаж байна.

Чадавхжиж, бидний шаардлагыг хангасан бүх аж ахуйн нэгж Монголын тансаг ширхэг буюу "Mongolian noble fibre" гэсэн шошгыг бүтээгдэхүүндээ зүүх эрхтэй болох юм. Монголын тансаг ширхэг гэж нэрлэсний учир нь үүнд сарлагийн савага, тэмээний ноос, ноолуур бүгд багтана.

Түүнчлэн цаашлаад бид арьс шир, савхи, савхин эдлэл, сүү сүүн бүтээгдэхүүн, жимс, чацаргана зэргийг брэнд бүтээгдэхүүн болох боломжтой өрсөлдөх чадвар өндөртэй бүтээгдэхүүн гэж үзэж байгаа. Жишээ нь, арьс шир боловсруулах үйлдвэрт химийн биш ургамлын идээллэгийг ашиглахыг туршиж үзсэн. Энэ нь байгаль орчинд халгүй, экологийн цэвэр арга юм. Үүнийг үргэлжлүүлэх нь чухал. Түүнчлэн монгол чацарганаар сайн бүтээгдэхүүн хийх, эсвэл жүүс болгох гээд олон боломж харагдаж байна.

Б.Эрдэнэбилэг: -Хөдөө, аж ахуйн тэр дундаа хөнгөн үйлдвэрийн салбар түлхүү хөгжиж ирсэн. Хөнгөн үйлдвэр дотроо бүтээгдэхүүн болгож болохуйц салбарыг сонгосон. Ингэхдээ юун түрүүнд ноос, ноолуур, арьс ширний салбар нь манай улсын хувьд харьцангуй зохион байгуулалтад орсон, чанар стандарт маркетингийн хувьд өндөр түвшинд хүрсэн гэж үзсэн учраас дэлхийн брэнд болгохоор зорьж ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт уул уурхайгаас хэт хамааралтай болж буй учир эдийн засгаа төрөлжүүлэх хэрэгтэйг хүн бүхэн л сануулж байна. Хөдөө, аж ахуйн салбар нь нэмүү өртөг шингээдэг, түүхий эд нь эргэн нөхөн сэргээгддэг давуу талтай. Бид энэ давуу талаа ашиглаж, дэлхийд брэндээ гаргах хэрэгтэй.

-Өнгөрсөн гуравдугаар сард ноос, ноолуурын салбарынхан нэгдэж "Mongolian noble fibre" гэсэн дэлхийн зах зээлд таниулах шошгоныхоо талаар ярилцаж, санал нэгдсэн. Түүнчлэн ирэх тавдугаар сард болох Нью-Йорк хотноо болох "Wool in the city" сэдэвт олон улсын ноосон, нэхмэлийн байгууллагын 81 дүгээр их хурлаар энэхүү логогоо урьдчилан танилцуулна гэж байсан. Энэ тухай сонирхуулахгүй юу?

Б.Эрдэнэбилэг: Нэлээд хэдэн жилийн өмнөөс ноос, ноолуурын компаниуд хамтран нэгдсэн логотой болохоор шийдэж байсан боловч энэ нь хэсэг хугацаанд яваад л унасан. Учир нь, цаана юу илэрхийлэх, яаж баталгаажих, хэрхэн хүлээн зөвшөөрөгдөх гэдэг нь тодорхойгүй, компаниуд эрхийг нь худалдаж авахаар байсан учраас үр дүнд хүрээгүй туршлага бий. Тиймээс бид Монголын ноос ноолуурын холбоо, ХХААХҮЯ-тай хамтарч компаниудад танилцуулсан. Уран бүтээлчдийн дунд логоны уралдаан зарлан, сүүлийн шатанд шалгарч үлдсэн зохион бүтээгч Б.Энхбат, Ж.Батбаяр нарын Хаан, Гэрэгэ гэсэн хоёр бүтээл дээр санал, шүүмжлэлээ хэлэлцэж, энэ хоёрыг илүү боловсронгуй болгохоор тохирсон.



Дэлхийн брэндийг илтгэх шошго нь ямархуу утгатай байх вэ гэдэг дээр мэргэжилтнүүдийн батлах тун дөхсөн хувилбараар бол монгол бичгээр хаан хэмээн бичиж, үндэсний хээ угалзаар чимэглэсэн байна. Хаан гэдэг үгийг яагаад сонгосон юм бэ гэвэл ноос, ноолууран бүтээгдэхүүн нь хаан хэрэглээг бий болгодог утгаар нь авч үзэж буй юм. Харин Гэрэгийн хувьд эртний хаад, ноёд төрийн албандаа өргөнөөр ашиглаж, зарлиг буулгадаг байснаараа хүндэтгэлийн утгатай. Ирэх сард Нью-Йорк хотноо болох хурал дээр бид Монголын ноос ноолууран бүтээгдэхүүн "Mongolian noble fibre" гэсэн шошготой, чанарын шаардлага бүрэн хангасан бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр хөл тавина гэдгийг дэлхий нийтэд зарлана. Харин компаниуд "Mongolian



Өнгөрсөн гуравдугаар сард Хонконгд зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн ярамагийн үеэр манайхаас ноос ноолуур болон арьс ширэн бүтээгдэхүүнийг танилцуулжээ. Үүний нэг нь Америкийн QuitMad Stop сүлжээгээр борлуулагдаж буй сарлагийн хөөврөн нөмрөг.

noble fibre" шошгийг ашиглахын тулд наад зах нь түүхий эд, эцсийн бүтээгдэхүүний хувьд чанар, стандартын шаардлагыг хангасан байх ёстой.

-Тэгэхээр дээрх шошгоо компаниуд хэзээнээс ашиглан, бүтээгдэхүүнээ дэлхийн зах зээл дээр гаргана гэсэн үг вэ?

Б.Эрдэнэбилэг: Ер нь нэг брэндийг дэлхийн зах зээлд гаргахад доод тал нь таван жил шаарддаг. Гэхдээ манайд бол ямар ч байсан гурван жилийн дотор бид брэндээ дэлхийд гаргасан байхаар төлөвлөж байгаа. Манайд өнгөрсөн оны есдүгээр сараас ирэх оны гуравдугаар сар хүртэл 18 сарын хугацаатай энэ төслийн эхний шат хэрэгжиж байгаа. Одоо бид шошгоныхоо ерөнхий загварыг сонгохоор ажиллаж байна. Үүнийгээ илүү сайжруулах нөгөө талаас компаниудынхаа чадавхыг сайжруулах, бүтээгдэхүүний дамжлага, түүхий эд, эцсийн бүтээгдэхүүний чанар гэх мэт чиглэлээр сургалтууд явуулж байгаа. Ингэхдээ олон улсын хэрэглэгчдийн таашаалд нийцсэн стандартын дагуу бүтээгдэхүүн гаргахад хаана, ямар дамжлага дээрээ алдаж буйг нь олж тогтоогоод, түүнийгээ засахаар ажиллах юм. Мөн энэ хугацаанд "Mongolian noble fibre" брэнд нь Монголдоо ирэх есдүгээр сард бүртгэгдэнэ. Түүнчлэн олон улсад албан ёсоор баталгаажсан байна. Ингээд шалгуур хангасан Монголын компаниуд уг брэндийг ашиглах нь тодорхой болно. Нэг ёсондоо бид дэлхийн зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад бэлэн болно гэсэн үг.

Мөн төслийн үр дүнд "Брэнд менежментийн агентлаг" байгуулахаар төлөвлөсөн. Гэхдээ одоогоор хаана харъяатайгаар үйл ажиллагаагаа явуулах нь тодорхойгүй байна. Энэ агентлаг ноос, ноолуурын брэндээ цааш нь илүү хөгжүүлэх чиг үүрэгтэйгээс гадна хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн бусад бүтээгдэхүүнд болон бүхий л боломжит салбарын брэндийг гаргахад анхаарлаа хандуулах юм. Түүнчлэн төслийн хоёрдугаар шат нь 3-4 жилийн хугацаатай байхаар Азийн хөгжлийн банк, Засгийн газрын хооронд яригдаж байна. Хэрэв асуудлыг шийдвэл хууль эрх зүйн хүрээнд чанар, ложистик бүх асуудлыг нь шийдэж ажиллана.

-Экспортын зах зээлд нийцсэн хөдөө аж ахуйн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд гаргахад манай зүгээс хамааралтай тулгамдаж буй асуудал юу байна вэ?

Юрген Мендритцки: Манай төслийн гол зах зээл нь Европын холбоо, Япон, Америк. Европын холбоо гэхэд л ноос, ноолууран бүтээгдэхүүний тал дээр нэлээд хатуу шаардлага тавьдаг. Энэ мэтчилэн бид хэрэглэгчдийнхээ хэрэгцээнд нийцсэн, тухайн орны шаардлага босгыг давсан дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь хамгийн чухал асуудал. Ингэхийн тулд бүтээгдэхүүний түүхий эд, боловсруулалт, үйлдвэрлэл гээд бүхий л дамжлага шатанд стандартын дагуу үйлдвэрлэл явуулах нь чухал байгаа юм. Брэнд бий болгох тал дээр бол хууль, эрх зүйн хүрээнд багагүй бэрхшээл тулгарах байх. Тухайн үед нь судлаад, шийднэ.

Б.Эрдэнэбилэг: Дэлхий нийтэд нэг брэндийг аливаа улсын зах зээлд нэвтрүүлэхэд 7-10 жилийн хугацаанд 20-иод сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж гаргадаг жишиг байдаг. Гэтэл манайд төслийн хувьд цаг хугацаа мөнгө төгрөгийн хувьд одоохондоо ийм боломж байхгүй.



Ургамлын идээлгээр боловсруулсан арьсан цүнх.



Ургамлын идээлгээр боловсруулсан iPad-ны гэр.



Сарлагийн хөөвөөр хийсэн хүзүүний ороолт

Тиймээс дэлхийн зах зээл дээр ноос, ноолууран бүтээгдэхүүнээ гаргах хоёр зам манайд бий.

Эхнийх нь дэлхий нийтэд өргөн ашигладаг хамтын маркетингийн арга юм. Энэ нь бид бусад орны ноос, ноолуурын алдартай брэндтэй шошгоо нэг дор байрлуулж давхар шошготойгоор өөрсдийн бүтээгдэхүүнийг гаргаж, танилцуулах боломжтой байгаа. Хэрэв тухайн улсын иргэдэд манай бүтээгдэхүүн таалагдаж эхлэх юм бол бид цаашлаад үйлдвэрлэлээ илүү өргөжүүлэх боломж нээгдэнэ. Одоогийн байдлаар Америкийн Patagonia, Quit mad stop, Канадын Cash-mereness, Английн Pure cashmere зэрэг брэндтэй хамтарч ажиллах талаар судалж байна. Дараагийнх нь “Цас согоот”, “Швейцарь” гэх мэт жижиг компаниудтай ажиллаж, бүтээгдэхүүний чанарыг нь сайжруулан “Mongolian noble fibre” гэсэн өөрийн брэндээрээ олон улсад гаргах боломж ойрхон байна. Бид энэ гарцаа л аль болох зөв зүйтэй шийдэх нь чухал. Дээр нь дотоодын болон гадаадын зах зээлийн судалгаа чухал.

Америк, Япон, Англи болон цаашлаад Франц, Герман, Итали улсын зах зээлийг сонирхож байгаа. Тиймээс тэдний зах зээл дээр ямар бүтээгдэхүүн эрэлт хэрэгцээтэй байгааг тодорхойлж гаргах болно. Есдүгээр сард эхлээд бүтээгдэхүүнээ сонгочихоод дараа нь борлуулалтаа хийе гэж байсан бол одоо энэ ойлголтын зөрүү гарсан. Ямар бүтээгдэхүүн авахыг нь эхлээд судалж, хэрэглэгчдийнхээ хүсэлтийн дагуу бүтээгдэхүүнээ гаргана. Дээр нь түүхий эдийн болон үйлдвэрүүдийн чанар технологи, чадавхыг сайжруулах нь хамгийн чухал.

-Хамтын маркетинг, брэндтэй болохын давуу тал нь юу байна вэ. Мөн хөдөө аж, ахуйн салбарын цаашдын хөгжлийг хэрхэн төсөөлж харж байна вэ?


Б.Эрдэнэбилэг: Эцсийн брэнд бүтээгдэхүүн гаргаснаараа эдийн засгийн хувьд томоохон хэмжээний түлхэц болно. Жишээлбэл, Монголын ноолуурын 80 хувийг түүхийгээр нь гаргадаг байсан бол үүнээсээ 50 хувьд нь нэмүү өртөг шингээж, эцсийн бүтээгдэхүүн гаргаад ирэхэд үр ашиг нь өснө. Энгийн жишээ хэлэхэд нэг кг ноолуурыг 50 мянган төгрөгөөр зардаг байлаа гэхэд үүгээрээ гурван цамц хийгээд зарахад л 150 мянган төгрөг болж үнэ нь гурав дахин өсөх байх жишээтэй. Салбарын хэмжээнд ийм зарчмаар ажиллаад ирэхлээр нэмүү өртөг илүү шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэр эрхлэгчид, эдийн засагт наалдсан тогтвортой өсөлт бий болно. Уул уурхайгаас гарсан ашиг хаашаа орсон бэ гэж гайхаж суух биш жинхэнэ гарт баригдаж, биед наалдсан эдийн засгийн өсөлт мэдрэгдэнэ. Төр, засгийн зүгээс гааль, татвар, Европын холбоотой хэлэлцээр хийгээд манай бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхэд боломжийг нь гаргадаг ч юм уу, Пакистан зэрэг улстай холбогдож болох юм. Монголын брэнд бүтээгдэхүүнийг гаргах нь зөвхөн нэг компанийн ажил биш ээ. Манай төслийн хувьд брэнд бий болох урьдач нөхцөлийг нь тавьж, суурийг нь босгож байгаа гэсэн үг. Одоо харин үйлдвэрлэгчид, малчид, төр, засаг, салбарын яам агентлагууд гээд хаа хаанаа анхаарч, салбарын хэмжээний бүтцийн өөрчлөлт хийж байж үр дүнд хүрнэ.

Юрген Мендритцки: Юун түрүүнд дэлхий нийтэд Монголын эерэг имижийг бүрдүүлж өгнө. Дээр нь дотоодын аж ахуйн нэгжүүд “Mongolian noble fibre” гэсэн брэндэд нэгдэхийн тулд хоорондоо өрсөлдөж илүү чанартай бүтээгдэхүүн гаргах болно. Мөн хөдөө аж ахуйн салбар нь эдийн засгийн салбартай багагүй дэмжлэг, түшиг тулгуур болж өгнө. Түүнчлэн үүнийг дагаад аялал жуулчлалын салбар ч түлхүү хөгжих хандлага харагдаж байгаа. Учир нь, тухайн ноос, ноолууран бүтээгдэхүүнийг хэрэглэсэн хүн өөрт таалагдсан бол үүнийг хаана, яаж үйлдвэрлэж, гаргаж авдгийг мэдэхээр Монголыг зорих болно. Харин энэ салбарын үйлдвэрлэлт, тоног төхөөрөмж, ажиллах хүчиндээ илүү их хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй юм.

Европын холбооны хувьд жишээ нь хөдөө аж ахуйдаа эртнээс анхаарч ихээхэн хөрөнгө оруулалт хийдэг. Харин зүүн Европын хувьд цөөн хэдэн тооны бүтээгдэхүүнд анхаарлаа хандуулдаг учир бусад нь орхигдоод байх шиг санагддаг. Түүхий эдийн бүтээгдэхүүний сүлжээ болон бусад үйл ажиллагааг нь хөндлөнгөөс хянах чиглэлд ажиллах нь чухал. Ингэхдээ судалгааны байгууллагууд болон Аудитын компаниудтай хамтарч чанарын хяналтыг сайжруулах нь салбарын хөгжлийн үндэс юм.

Мөн дэлхий нийтийн жишигт түүхий эдийн дуудлага худалдааг жил бүр явуулах нь зах зээлийн ил тод байдлын хангах нэг хэлбэр байдаг. ■

ШИНЭ НОМ




“Ус ба говь”

“...Хүнд буян хийе гэвэл тархинд нь мэдлэг өг. Байгаль дэлхийд буян хийе гэвэл хэвлийд нь ус тогтоо”

Бурхан багшийн сургаал

Усны Үндэсний төвийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер, техникийн ухааны доктор Ж.Далайгийн “Ус ба говь” номыг танилцуулж байна. Монгол орны эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн эх үүсвэр болсон уул уурхай болон эрчим хүчний томоохон бүтээн байгуулалт гол төлөв говийн бүс нутагт өрнөж байгаа тул усны асуудлыг үндэсний хэмжээнд хэлэлцэх боллоо. Тиймээс говийн усны асуудлыг шийдэхийн тулд Монгол орны хойд бүсийн гадагшаа урсан гарч байгаа голуудын хур бороony болон хаврын шар усны үерийн усыг хуримтлуулан томоохон усан сан бий болгож, усны нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатай хэмээн онцолжээ.

Монгол орны усны салбарын өнөөгийн байдал, Дэлхийн томоохон усны байгууламжууд, Монгол оронд усны салбарыг хөгжүүлэх шаардлага, Монгол орны гадаргын усыг ашиглах боломж гэсэн дөрвөн үндсэн бүлгээс мэдээлэл авч болох нь. Мөн хавсралт хэсэгт усны талаарх нийтлэл, ярилцлага, мэргэжилтний үг багтжээ. Гадаргын усны нөөцийг ус элбэг үед нь усан санд хуримтлуулж аваад ус бага, ган гачигтай үед нь гол горхи тэжээж түүнийг байнгын жигд, амьд урсгалтай байлган, голын дагуу амьдарч байгаа ард олон, ус хэрэглэгчдийг усны нөөцийн хомсдолоос сэргийлэх төсөл, саналыг буруу ташаа ойлгосон зүйл гарч бусдыг гайхшруулж эргэлзээх, тээнэгэлзэх байдалд оруулах болсон тул асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлан бичжээ.



Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь

Нээлттэй нийгэм форум Азийн хөгжлийн банктай хамтарч “Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь” номын эхний хэсгийг орчуулж хэвлэлтэд гаргасныг “Шинэ ном” буландаа танилцуулж байна. Уг номыг Азийн хөгжлийн банкны засаглал, төрийн удирдлагын асуудал хариуцсан зөвлөх доктор Салватор Шиаво- Кампо болон Энэтхэгийн төрийн захиргааны албанд 32 жил ажилласан туршлагатай судлаач Пачампет Сундарам нар 2004 онд англи хэлээр хэвлэсэн аж.

Харин манайд Төрийн захиргаа, эдийн засгийн менежментийн магистр Ц.Даваадулам, Төрийн удирдлагын магистр Ган.Батбаяр нар орчуулжээ. Энэхүү номд Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө нөөцийн удирдлага, Засгийн газар ба иргэдийн харилцаа, захиргааны шударга байдал, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн үйлчилгээг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх зэрэг төрийн захиргааны олон асуудлыг цогцоор хөнджээ.

“Монголын эдийн засаг эрчимтэй өсч, төсвийн орлого эрс нэмэгдэж байгаа өдгөө цагт нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанар, хүн амын амьжиргааны түвшинг тэр хэмжээгээр сайжруулах нь нэн тулгамдсан зорилт болж байна. Авлигаас ангид, хариуцлагатай, ёс зүйтэй, мэргэшсэн төрийн албатай байж гэмээнэ энэхүү зорилт хангагдана.

Манай улсад ийм төрийн алба хараахан бүрэлдэн бий болоогүй байна. Иймээс төрийн захиргааны шинэтгэлийг дээрх зорилтод чиглүүлж, даяаршил, эрх мэдлийн задрал зэрэг орчин цагийн нөхцөл байдалтай уялдуулан цогцоор нь авч хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж буй энэ үед энэхүү номоо хэвлэн гаргаж буй нь олзуурхууштай зүйл юм” гэдгийг номын нээлтийн үеэр ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал хэллээ.

Тус ном дөрвөн хэсэг есөн бүлгээс бүтсэн 800 орчим хуудастай. Агуулгын хувьд нэгдүгээр хэсэгт Засгийн газрын бүтэц түүний зохион байгуулалтын талаар түлхүү авч үзжээ. Харин хоёрдугаар хэсэг нь Засгийн газрын хөрөнгө нөөцийн удирдлагад анхаарсан байна.

ТОД ТАМГА

БИШИРТҮГЭЙ! АЮУТУГАЙ!



ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ ХҮРТ!

Утас: 91919499, 323454 www.todtamga.mn
Хаяг: ЧД, Татварын Ерөнхий газрын ард
“ТОД ТАУЭР” оффис, 101 тоот
Утас: 98907234

САЛБАРУУД:

Баруун 4 зам	**Утас: 98626587 todtamga2@yahoo.com**
Зуун айл	**Ута: 98907912 todtamga1@yahoo.com**
Түгээмэл	**Утас: 98630499 todtamga3@yahoo.com**